

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:*

1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:*

3-44

---

1. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны  
өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

3-44

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 02-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 10 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтаншагай;

Томилолттой: Х.Баттулга;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Э.Батишугар, О.Цогтгэрэл.

**Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Д.Энхтуул, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Эрдэнэс үйлдвэр технологийн парк” ХХК-ийн гүйцэтгэх захирал Х.Мөнх-Идэр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, мөн албаны референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Н.Батсүмбэрэл, Х.Ганхуяг, О.Батнайрамдал, Г.Лувсанжамц, М.Энхцэцэг, М.Бадамсүрэн, Б.Мөнхсоёл, Л.Соронзонболд, Д.Энхтүвшин, М.Мандхай, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга А.Хишигбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 35 минут үргэлжилж, 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 45 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

**Р.СЭДДОРЖ**

**Тэмдэглэл хөтөлсөн:**

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 02-н өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим,  
14 цаг 10 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Р.Сэддорж:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Та бүхэндээ намрын чуулганы мэнд хүргэе.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Орон нутагт чөлөөтэй Алтанишагай гишүүн, орон нутагт чөлөөтэй Баттулга гишүүн нар байна. Ирц 56 хувьтай байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газар 2024 оны 9 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг явагдана.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн талаарх Засгийн газрын танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөр танилцуулна. Сайдын микрофоныг нээнэ үү.

**Л.Гантөмөр:** Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг та бүхэндээ танилцуулах гэж байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө өргөн баригдсан. Гишүүдийн гар дээр ирсэн байгаа. Та бүхэн уншиж танилцсан байгаа гэдэгт итгэж байна. Танилцуулгыг аль болохоор товчлоод танилцуулъя гэсэн бодолтой байна.

2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтод уялдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас санаачилсан “Хүнсний хувьсгал” хөтөлбөр, “Цагаан алт” үндэсний хөтөлбөр, Монголд зочлох жил, Залуучуудын жил, Шинэ хоршоо, Чинээлэг малчин, Атар-4 дүгээр тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн нэн тэргүүнд хэрэгжүүлэх бодлогын төсөл, арга хэмжээнүүдийг тусгалаа.

Дээрх зорилго, зорилтод хүрэхэд 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх

чиглэл нь урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурийг бэхжүүлэх бөгөөд эдийн засаг, бүсчилсэн хөгжил, хүний хөгжил, хүний эрхийг дээдэлсэн засаглалын үндсэн бодлогын хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудад үндэслэн тодорхойлж, шаардлагатай салбарууд дахь реформуудыг шуурхай эхлүүлж, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхийг зорьж байна.

Эдийн засгийн бодлогын хүрээнд урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь дэд бүтцийг бий болгох 14 мега төслийг 2025 ондоо багтааж бүрэн эхлүүлэхээр төлөвлөж байгаа. Макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, зах зээл дэх төрийн оролцоог хялбарчилж, салбаруудад бодлогын цогц реформуудыг хийх ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Эрчим хүч, Зам тээвэр, ХАА, банк санхүүгийн салбарт бодлогын цогц шинэчлэл, мөн либералчлалыг хэрэгжүүлж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийг зорино.

Уул уурхайн салбарт тусгай зөвшөөрлүүдийг ил тод болгож, уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалдаг бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, биржийн тогтолцоог бэхжүүлнэ.

Мөн шинжлэх ухаан, технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулах бодлогыг хэрэгжүүлнэ.

Хувийн хэвшилд тулгуурласан бизнесийн орчныг дэмжиж, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

Дижитал эдийн засаг, ногоон эдийн засгийг бодитой нутагшуулж,

старт ап, инновацыг дэмжих бодлого хөшүүргийг тодорхойлж хэрэгжүүлнэ.

Гадаад худалдаан дахь техникийн болон тарифын саад тотгорыг арилгаж, гадаад зах зээлд өрсөлдөх чадвар бүхий экспортыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, төрөлжүүлжүүлэх замаар олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, эдийн засгийг тэлэхийг зорино.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд байгалийн баялаг, нөөц, байршлын давуу талд тулгуурласан бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлж, бүс бүрд ач холбогдолтой томоохон төслүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, ТЭЗҮ-ийг боловсруулна. Бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх татварын ялгаатай бодлогыг 2025 оноос эхлэн хэрэгжүүлж, бүс орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бүс бие даан хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн бодлогоор өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ.

Орон нутгийн төвлөрлийг дэмжих хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшиж байгаа иргэд, ААН-д үзүүлэх бодлогын дэмжлэгийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Улаанбаатар хотыг 20 минутын хот буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040 болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна.

Дагуул хотуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэхийг зорьж байгаа.

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд иргэн бүр тэгш эрхтэйгээр нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах, орлого олох, хөгжих боломжийг бүрдүүлэхэд

чиглэсэн гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт нийцүүлсэн бодлогыг хэрэгжүүлэх юм.

Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж, тус сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд төлбөрийн чадварт нийцсэн орон сууц, байгальд ээлтэй амины орон сууцын хүртээмжийг бодлогоор дэмжинэ.

Хүн амын бүлгүүдийн онцлогт нийцүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэх зорилгоор бүх түвшний сургалтын байгууллагын чанар, суралцах орчныг сайжруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг эрчимжүүлнэ.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд төрийн үйлчилгээний цахимжилт процессын дахин инженерчлэлийг үргэлжлүүлж, шийдвэр гаргалт, үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглан бүрдүүлж, иргэдэд ойр төрийн үйлчилгээг бий болгохыг зорино.

Мөн төрийн албаны реформыг хэрэгжүүлж, үр ашиг хүртээмжийг нэмэгдүүлэн чадварлаг, ухаалаг төрийн албаны тогтолцоог төлөвшүүлнэ.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, сайн засаглалын

зарчмаар үйл ажиллагаа явуулахыг дэмжинэ.

Авлига, хүний эрх, хувийн эрх зүйн шинэтгэлийн реформыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх юм.

Эдгээр бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд тодорхойлсон төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр Монгол Улсын эдийн засаг 2025 онд 8 хувиар өсөж, экспорт 19 тэрбум ам.доллар-т хүрснээр, гадаад валютын улсын нөөц нэмэгдэж, инфляц зорилтот түвшинд хадгалагдана.

Мөн ядуурлын бууруулж, хүний хөгжлийн индекс, засаглалын индекс, дэлхийн сайн орны үзүүлэлтийг тус тус сайжруулахыг зорьж байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг батлах Улсын Их Хурлын тогтоолыг та бүхэн хэлэлцэж баталж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Идэшийн Батхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Лханаажавын Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Нэргүй Мягмар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сэрээтэрийн Жавхланбаатар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бригадын генерал Дагвадоржийн Ганхуяг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагдоржийн Батболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Төмөрхуягийн Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны



яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Пушаагийн Алтан-Од, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дагвадоржийн Очирбат, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Болдын Цэнгэл, “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал Санжаагийн Наранцогт, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэвээндоржийн Эрдэнэбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Лхагвабаярын Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Доржготовын Баттогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлогын газрын дарга Харнүдэнгийн Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга Амарсайханы Хишигбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Дугаржавын Амгалан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамьяншаравын Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Зияханы Райымбек, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Дашижамцын Энхтуул, “Эрдэнэс үйлдвэр технологийн парк” ХХК-ийн захирал Мөнх-Идэр нар хүрэлцэн ирсэн байна.

Соёлын яамнаас алга байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас алга байна.

ЭХЯ-наас төрийн нарийн ирээгүй байна. Спорт, соёл, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүүгийн газрын дарга ирээгүй байна. Эрүүл мэндийн яамны газрын дарга ирээгүй байна.

Гишүүдэд асуултыг зарлахаас өмнө сонгуулийн жил давхацсанаас шалтгаалж, жилийн төлөвлөгөө хуулийн хугацаандаа баталж амжаагүй. Улсын Их Хурлаар төсвийн төсөл хэлэлцэх үед гишүүд санал гаргахад жилийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтуудад үндэслэх ёстой. Тиймээс жилийн төлөвлөгөөг төсвийн хэлэлцүүлгийн өмнө яаралтай заавал батлах шаардлагатай байгааг дурдаж байна.

Гишүүдэд сануулахад, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл дээр зарчмын зөрөөтэй санал гаргахаар бол дэгийн тухай хуулиар саналаа төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2 хоногоос доошгүй өдрийн өмнө бичгээр ирүүлсэн байна гэж заасан байгаа.

Ийм учраас дараагийн хурлаас ирэх 7 хоногийн 3 дахид орчим болов уу, дараагийн хурлаас 2 хоногийн өмнө бичгээр ирүүлсэн саналыг оруулах ийм дэгийн хуультай юм байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Энхтүвшин гишүүнээр тасаллаа.

Ж.Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Төлөвлөгөө баталж байхад уул нь сайд нар байх ёстой л доо. Угаасаа байдаг байсан юм л даа. Төрийн нарийнууд нь ч хагас нь ирсэн юм уу, ирээгүй юм уу тийм л юм сонсогдож байх шиг байна.

Энэ 2 асуулт байна. Биржийг сая Гантөмөр сайд уншихдаа 25 онд

өргөжүүлнэ гээд унших шиг боллоо. Тэгээд Эрдэнэс тавантолгой компани биржээр яагаад нүүрсээ зарахгүй байгаа юм бэ? Эхний 6 сарын байдлаар, эхний 6 сарын байдлаар Эрдэнэс тавантолгой компани нийт экспортолсон нүүрснийхээ 70 хувийг биржээр зарж байсан байна. Наранцогт дарга аа. Тэр 5 номер дээр сууж байгаа дарга. 70 хувийг нь биржээр зарж байсан байна. Одоо Эрдэнэс тавантолгой компани 15 хувиа зарсан байна. Сүүлийн хагас жил. Шалтгаан нь юу юм бэ? Яагаад хууль биелүүлэхгүй байгаа юм. Дундаж үнэ нь эхний хагас жилд 140-150 доллар байсан байна. Өнөөдөр 96 доллар болсон юм байна. Үүнийг төрийн байгууллага гаргаж өгч байгаа шүү, би гаргаагүй. Энэ тэр Ганбат өөрөө сууж байх шиг байна. Бид нар биржээр нүүрсээ зарахад мянган проблем байсан шүү. Энэ Ганбаатарыг сайдаас нь явуулж байж л нэг сэтгэл амрах юм байна гэсэн хэсэг бүлэг хүмүүс байсан юм. Түүнийгээ биелүүлэх гэж байгаа юм байлгүй дээ. Эрдэнэс тавантолгой компани экспортолдог нүүрсээ ижил хэмжээнд экспортлоод л байх юм. Тэгсэн мөртөө биржээр арван долоохон хувиа зарсан байна, 15 хувиа. Үгүй энэ хууль яагаад биелүүлэхгүй байгаа юм. Энэ чинь 100 хувиа биржээр зарах хуультай шүү дээ. Төрийн өмчит компани.

Тэгээд яаж нүүрсээ зараад байгаа юм бол. Тэгээд хэн тэр Эдийн засгийн хөгжлийн сайдын ярианд бол олон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ, зөв. Сайн байна. Тэгээд юугаар хөдлөх гэж байгаа юм? Наад тэр валютын нөөц нэмэгдсэн гол шалтгаан чинь наад биржээр нүүрсээ зарсны ач холбогдол шүү дээ. Түүхэнд байхгүй мөнгөтэй болсон, Монгол Улс. Бэлэн мөнгөтэй болсон. Тэгээд одоо яагаад биржээр нүүрсээ зарахгүй байна. Нүүрсний үнэ яагаад санаатайгаар унагаагаад байгаа юм. Надад бол янз янзын мэдээлэл ирж байгаа шүү. Тодорхой хариулт авахыг хүсье.

2 дугаарт, энэ Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх намайг анх сайд болоход нэг хүсэлт тавиад, зэсийг биржээр зар, Эрдэнэт үйлдвэрийн зэсийг биржээр тарих хүсэлт тавьсан юм. Тэгээд 4 сар, 5 сар 2-т бирж, юу зэсээ зарсан юм. Наранцогт дарга мэдэж байгаа байх. Тэгээд 1 удаад 3 мянган тонн зэс зараад Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмал зараад 1,1 тэрбум төгрөгийн илүү орлого олсон. Тэгээд өнөөдөр байхгүй, ерөөсөө 6 сараас хойш 1 ч зараагүй байна.

Тэгээд сураг сонсох нь бас л мянган проблем одоо шалтаг. Би өөрөө наад нүүрсийг чинь удирдаж байсан, зэсийг чинь удирдаж байсан, шалтгуудыг нь бол маш сайн мэднэ. Тэнд нүүрс авахгүй байна, тэнд бослого гаргах гэж байна, тэр компани татан авалтаа хийхгүй байна, Хятадууд ийм юм ярьж байна. Тэр сайд ингэж байна, энэ сайд ингэж байна гээд. Зэсээ яагаад биржээр зарахгүй байна. Яагаад хууль биелүүлэхгүй байна.

**Р.Сэддорж:** Хариултыг нь дараа юу? Холбогдох хариултауд өгье. Уул уурхайн яам. Эрдэнэс Монголын захирал хэдэн номерт байна. Наранцогт дарга 4 номер уу? 4 номерын микрофон нээе.

**С.Наранцогт:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Шинээр борлуулж байгаа бүх нүүрс бол биржээр зарагдаж байгаа. Энэ дээр ер нь биржээ зарагдахгүй, биржээ зарахгүй гэсэн ойлголт байхгүй. Биржийн хууль бол бүрэн хэрэгжээд явж байна.

Эрдэнэс тавантолгой компанийн гүйцэтгэл бол борлуулалтын гүйцэтгэл 106 хувьтай явж байгаа. Тэгэхээр үнэ багассан талаар ярьж байгаа. Үнэ бол цэвэр энэ биржийнхээ журмаар дуудлага худалдаагаар дуудах үнээ өгөөд оролцож байгаа компаниуд үнэ хаялцаад ингээд үнэ тогтож байгаа. Энэ бол Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн агшилттай холбоотойгоор ер нь бол зах зээлийн үнэ



өөрөө бууж байгаа гэсэн ойлголттой байгаа. Энэ дагуу үнэ бол жоохон буусан. Гэхдээ нүүрс бол биржээр зарагдаж байгаа.

Эрдэнэтийн зэсийн хувьд бол таныг сайд байх үед үүнийг 5 хувь хүртэл зарах гэдэг санаачилга гаргаад, тэгээд анхны дуудлага худалдаанд нь тэр олон жил энэ трэйдер хийж байгаа компани нь өөрөө бас санаачилга гаргаж орж нэг удаа авсан юм билээ. Дараа нь бол 2, 3 удаа дуудлага худалдаа зохион байгуулаад энэ нь зарагдаагүй, дуудлага худалдаа амжилтгүй болсон гэдэг ийм зүйл яригдаж байгаа. Үүнийг шалтгааныг нь ингээд үзэхээр тэр аргачлалынхаа асуудалтай байгаа зэсийн энэ хайлуулах үйлдвэрийн зах зээл өөрөө их энэ жилийн хувьд бол нэлээн онцлогтой. Өөрөөр хэлбэл хайлуулах үйлдвэрийн хүчин чадал нь бол дэлхийн зах зээл дээр их илүү байгаа юм байна лээ.

Тийм учраас тэр металл цэвэршүүлэх гэдэг үнийн тохируулгын асуудал нь бол энэ манай одоо явагдаж байгаа энэ биржийнхээ зохицуулалт дээр тэр зах зээлтэйгээ уялдаж өгөхгүй байгаа гэдэг нэг шалтгаан байгаа. Үүнээс болоод бол 2, 3 удаа явсан дуудлага худалдаа амжилтгүй болсон. Мэдээж хэрэг цаашидаа бол энэ биржээр түүхий эдийг борлуулах гэдэг бодлого Засгийн газар бол хатуу баримталж байгаа.

**Р.Сэддорж:** Жамбалын Ганбаатар гишүүний тодруулга.

**Ж.Ганбаатар:** Наранцогт дарга аа, одоо загнаад байх хэцүү юм даа. Та худлаа яриад байна шүү дээ. Нийт гаргасан нүүрсний чинь арван долоохон хувиа зарсан байна. Та өөрөө тоо баримтаа нягтлаач дарга аа. Би эс үгүй бол чамд уншаад өгье. Би энэ чинь эрх бүхий газраас авсан тоо баримт шүү, би өөрөө гаргаагүй. Монгол Улс тоо баримт нэгтгэдэг газар байгаа шүү дээ.

Тэгэхээр эхний энэ чинь нэгхэн минут байх аа даа. Та эхний хагас жилд Эрдэнэс тавантолгой 40 сая тонн нүүрс зарсан. Түүний 14,6 сая тонныг нь биржээр зарсан. Үүний биш ээ, 10 сая тонн нүүрс Эрдэнэс тавантолгой арилжсан. Ингээд 70 хувийг нь та биржээр зарчихсан байгаа байхгүй юу. Одоо сүүлийн хагас жилд энэ биржээр зарсан чинь 1,4 сая тонныг л Эрдэнэс тавантолгой компани арилчихсан байна. Нийт биржээр зарсан чинь бол 3,2 сая. Түүний 1,4 арван тавхан хувиа зарсан байна. Наад зэс дээр чинь бол үнэ нь ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт.

Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** 2 янзын асуулт байна. Энэ Эрүүл мэндийн яамнаас асууя. Эхний асуулт энэ хүн ам нятрал ихтэй байгаа. Ялангуяа Улаанбаатар хотод эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж дутмаг байгаад байдаг. Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний хүртээмж, өрхийн эмнэлгүүдийг бэхжүүлэх асуудал нэг талд бодитоор хэрэгцээ байна.

Дээрээс нь төрөлжсөн чиглэлийн эмнэлгүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага байна. Дүүргүүдийн нэгдсэн эмнэлгүүдийг мөн бэхжүүлэх. Ялангуяа тэр орчин үеийн тоног төхөөрөмж дээр ажиллах мэдлэг чадавхтай, мэргэжилтний бэлтгэх, сургах, дадлагажуулах, ажлын байрандаа тогтмол төрийн өмчийн эмнэлэгт ажиллах бололцоогоор хангагдаж өгөх талаар ажлууд явуулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа.

Энэ дотор эрүүл мэндийн салбар дээр улс төржсөн байдал нэлээн хавтгайрах шинжтэй бий, харагддаг. Тэгэхээр энэ асуудлууд дээр Эрүүл мэндийн яам ер нь ямар бодлого барьж ажиллаж байна? Саяын яриад байгаа энэ эмнэлгийн хүртээмжийн асуудлыг

яаж үзэж байна? Эмнэлгийн мэргэжилтэн боловсон хүчнийг сургах, бэлтгэх, дадлагажуулах, ажлын байранд тогтвортой ажиллах тал дээр нь ямар стратеги байна гэдэг дээр хариулт авъя.

Дараагийнх нь тэр Эдийн засгийн яам байх аа даа. Дээрээс хойш би хөндөөд байгаа. Энэ бид нар олон асуудлуудыг ярьж шийдэх ёстой байгаад байгаа. Бүсчилсэн хөгжлийн асуудлыг энэ удаагийн парламент нэлээн онцгойлж авч үзэж байгаа. Гол бичиг баримтуудынхаа малгайд ч тавиад явж байгаа. Сонгуулийн тогтолцоо, юу бүтэц маань ч өөрөө энэ чиглэл рүү бүрдсэн.

Тэгэхээр энэ сумуудыг шинэчлэн зохион байгуулах ажлыг хийх, үүний бэлтгэл хийх талын ажлууд энэ төлөвлөгөөнд орж байна уу? Энэ дээр та бүхэн ер нь юу хийж байна? Хамгийн эхлээд тэр 21 сумыг татан буулгамаар байгаа юм. Өөрөөр хэлбэл аймгийн төв дээр байдаг сумууд ямар ч хэрэг алга. 21 Засаг дарга, 21 Засаг даргын орлогч, 21 Тамгын газрын дарга, 21 сумын иргэдийн хурлын төлөөлөгч нар ойролцоогоор 450 орчим хүнийг бид цөөлбөл, энэ эдийн засгийн хувьд, эрх мэдлийн төвлөрлийн хувьд өөр байдалтай байх нь байна.

Төв аймгийн төвд Зуунмод гэдэг сум яг хэрэгтэй юу? Увс аймагт Улаангом гэдэг сум сумын иргэдийн хуралд хэрэгтэй юу? Энэ асуудлыг та нар судалж үзэж байна уу? Өөрөөр хэлбэл тодруулаад яривал 550 даргыг бид нар цөөлөх гээд байна шүү дээ. 21 Засаг дарга, орлогч, Тамгын дарга, 450 орчим хурлын төлөөлөгчийг.

Тэгээд эдгээр асуудлыг та бүхэн судалж байгаа юу? Эдийн засгийн тооцоололтоо хийнэ гээд Эдийн засгийн сайд нь нэг ярьчихсан байсан харагдаж байсан.

Хил орчмын сумуудаа бэхжүүлэх талын бодлого байж болох. Тэгэхээр энэ бүсчилсэн хөгжлийг бид нар нэгэнт

явуулах гэж байгаа тохиолдолд сумуудыг нэгтгэн зохион байгуулах шаардлага байгаа. Энэ дээр энэ судалгаа байна уу?

2 дахь нь энэ бүсийн төвүүдийг яаралтай бий болгохгүй бол бидний эхлүүлсэн энэ 6 бүс маань өөрөө яваандаа бүдгэрчих вий. Цөөн бүсийн төв нь яг чухам аль нь вэ? Эдийн засгийн болон бусад хүчин чадлынхаа ирээдүйн хөгжлийн нөөц бололцоогоороо аль нь вэ? Үүнийг та нар тооцож үзэж байгаа юу? Энэ асуултууддаа хариулт авъя.

**Р.Сэддорж:** Сайд хариулах уу? Эрүүл мэндийн яам байна. 6 номер. 6 номерын микрофон өгье. Төрийн нарийн бичгийн дарга Очирбат.

**Д.Очирбат:** Эрхэм гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн салбарт анхан шатны тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах тал дээр олон төрлийн арга хэмжээг авахаар төлөвлөж тусгасан. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд дээр Улаанбаатар хотод хүлээгдэж байгаа нэгдсэн төрөлжсөн эмнэлгүүд дээр байгаа хагалгаануудыг тийш нь шилжүүлэх, бүсийн оношилгоо эмчилгээний эмч нарыг сургах, Эрүүл мэндийн яам дээр өнөөдрийн байдлаар 13 дотооддоо эмчлэгдэж чадахгүй байгаа 25 нэр төрлийн өвчний заалттай. Тэрийгээ бол гадаадад сургаж, эмч нараа гадаадад сургах багийг бэлдүүлж гадагшаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар 13 баг, эмч нарыг бэлдэж гадаад, дотоодын сургалтад хамруулж байгаа.

Түүнийхээ зэрэгцээгээр мөн гаднын туршилагатай эмч нарыг, эрүүл мэндийн багийг анхан шат дээрээ авчирч сургах, хөдөө орон нутагт ажиллуулах ажлуудыг бас хийж эхлүүлээд байна гэж.

Тэр дүүргийн нэгдсэн, дүүрэг дээр бол бас төрөлжсөн эмнэлгүүдийг нэмэгдүүлэх, дүүргийн нэгдсэн эмнэлгийг

сайжруулах тал дээр Азийн хөгжлийн банкны тусламжтайгаар бид хэд эхнээсээ СХД, ХУД, ЧД дээр нэгдсэн жишиг эмнэлгүүдийг барьж явж байгаа. Энэ жишиг эмнэлгийн хүрээндээ бүх эмч нарыгаа сургаж, сургалтад хамруулж, тоног төхөөрөмжийн жишиг дүүргийн нэгдсэн эмнэлгийн хэмжээнд авч хэрэгжүүлж явж байна гэж.

Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүддээ төрөлжсөн эмнэлгүүдийн төвүүдийг бас байгуулж байгаа. Жишээлэхэд Халдварт өвчин судлалын төв, Зүрхний төв. 4 бүс дээрээ бол Бүсийн оношилгоо эмчилгээний төрөлжсөн мэс заслын баг хотын төвлөрөлт, одоо нэгдсэн төрөлжсөн эмнэлгүүд дээр байгаа ачаалал үүсээд байгаа Хавдар, 1, 2, 3 дугаар эмнэлэг дээр үүсээд байгаа төвлөрлийг сааруулах тал дээр үндэсний багийг төрөлжүүлэн ажиллуулж, сурах ажлуудыг хийж үргэлжлүүлж байна.

**Р.Сэддорж:** Гантөмөр сайдын микрофоныг өгье.

**Л.Гантөмөр:** Эрхэм гишүүний асуултад хариулъя. Бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын хуулиараа Шадар сайд Амарсайхан хариуцаж байгаа. Амарсайхан дээр Эдийн засаг, хөгжлийн яам дээр байсан бүсчилсэн хөгжлийн бодлогын алба Амарсайхан Шадар сайдын ажлын алба руу бол шилжсэн. Тэгэхээр тэндээс их тодорхой бодлогууд гарна.

Дээр нь бүсчилсэн хөгжлийнхөө бодлогыг гаргахад зориулаад бид нар Шадар сайдын доор яг энэ чиглэлийн Алба байгуулчихсан байгаа. УУГ гэж ойлгож болно. Тэгэхээр бүсчилсэн хөгжлийг бид нар мэдээж холын зургийг нь гаргах нь эхлээд их чухал байна. Нөөцийг нь бүрэн тодорхойлох шаардлага байгаа юм. Түүнээс биш механикаар их хурдан хийх амархан. Сумдыг татан буулгаад эсвэл хот гэж заримыг нь зарлаад, бидэнд бэлэн төсөл

байна шүү дээ. Дархан хот гэж зарлая. Тэгэхээр Сэлэнгэ аймгийг Дарханыхаа газар нутагтай нэгтгэж бол ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя. Гантөмөр сайдын микрофоныг өгье.

**Л.Гантөмөр:** Тийм, тэр механик алхмууд бол тийм хугацаа зарах зүйл бол биш. Хамгийн гол зүйл говийн бүсийн хөгжлийн төлөвлөлтийг гаргая гэж байгаа юм. Баруун бүсийнхээ хөгжлийн төлөвлөлтийг гаргая. Зүүн бүсийн хөгжлийн төлөвлөлтийг гаргая.

Тэгээд бид үзэл баримтлалынхаа хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлахдаа бүсүүдийнхээ төрөлжилтийг гаргачихсан. Одоо тэр төрөлжилтөд нийцсэн хөгжлийн бодлогыг нь гаргаж байгаа. Бодлогын эхний алхмууд бол бид нар өнгөрсөн төсвийн тодотголыг батлахдаа 60 тэрбум төгрөг баталсан, тийм ээ. 6 бүс дээрээ 10, 10 тэрбум төгрөгөөр ТЭЗҮ болоод замын зургийг нь гарга гээд. Тэгэхээр ондоо багтаад энэ зураг бол бүтэн гарна. Бүтэн гарахаар аандаа таны хэлж байгаа Засаг захиргааны нэгжийн хууль чинь яах юм бэ, засаг захиргааны нэгжийн өөрчлөлт чинь хэрхэн явах юм бэ гэдэг энэ зүйл бол араасаа холбогдоод шат дараатай гараад явах юм. Бид их хурдтай явна. Тэгэхдээ бодлого нь алдаагүй ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Тодруулга  
Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Тэр эдийн засгийн нөөц тооцоололд тулгуурлаад хийх ёстой гэдэг дээр санал нэг байгаа. Зүгээр гол анхаараад хараад байгаа юм бол бид ингээд юмаа хэлэлцээд явж байтал 24 он дууслаа. 25, 26, 27 он ингээд бүрэн эрх дуусна. Гэтэл энэ ажил маань урагшаа явахгүй байж байгаад хоцрогдчих вий, ухарчих вий. Хуучин нөгөө 76 жсалганд хуваагддаг байсан бол

126 нүхэнд хуваагддаг болчих вий гэж л эмээгээд байгаа.

Тэгээд бид энэ том зургаар хөгжихийн тулд эдийн засгийн том нөөцүүдээ эрэмбэлэхийн тулд энэ жижиг жижиг сумуудыг цэгцэлье. Үүнийг та бүхэн олон намууд нэгдсэн дээрээ иуурхай Засгийн газар дээр явуулаач гэдэг юмыг л яриад байгаа юм. Энд бас чадлаараа миний хувьд оролцох юм бол бас оролцоод явахад бэлэн.

**Р.Сэддорж:** Гантөмөр сайд тодруулгад нь хариулах уу. Санал уу.

Баярлалаа. Хассуурийн Ганхуяг гишүүн. Ганхуяг гишүүний микрофоныг өгье.

**Х.Ганхуяг:** Энэ өдрийн мэндийг хүргэе. Эдийн засгийн хөгжлийн яам болон холбогдох яамнуудаас асууж байгаа. Бид нар Их Хурал дээр нэлээн ажлын хэсэг байгуулаад, бизнесийн орчныг сайжруулна. Нэлээн олон салбарын хуулиуд бас хөндөгдөөд ажлын хэсгүүд байгуулагдаад явж байгаа.

Тэгэхээр энэ маань яг Засгийн газрын төлөвлөгөөтэй хэрхэн яаж уялдаж байгаа талаар бас нэг асуучихмаар байна.

2 дугаарт, энэ төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулна гээд энэ төлөвлөгөөнд орсон байх. Заримыг нь нээлттэй ХК болгоно гэдэг бас зүйл орсон байна.

Тэгээд Их Хурал дээр төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг эрх зүйн орчин нь бий болгох гээд бас ажлын хэсэг бий болчихсон явж байгаа. Хоёрхон жишээ хэлье л дээ. Одоо жишээлбэл Эрдэнэс тавантолгой компани бусад төрийн өмчит компаниудад 2,7 их наяд төгрөгийн зээл олгосон байдаг. Энэ хэзээ, яаж буцааж төлөгдөх вэ? Энэ бол Баялгийн санд хуримтлагдах ёстой мөнгө. Иргэдэд ноогдол ашгаар очих

ёстой мөнгө. Мөн эрүүл мэнд, боловсрол, орон сууцын хөтөлбөрт зориулагдах ёстой мөнгө. Хэний шийдвэрээр ийм зээл олгогдсон, хэзээ буцааж төлөгдөх талаар. Мөн цаашидаа ийм хоорондын ашиг сонирхлын зөрчилтэй ийм зээлүүд олгогдох эсэх талаар тодруулчихмаар байна.

2 дугаарт, жишээ. Төрийн өмчит компаниуд хувийн хэвшилтэйгээ өрсөлддөг болсон байгаа. Би банкны салбар яриад яах вэ. Хамгийн энгийн жишээ хэлэхэд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит компани, ХК. Тендерт оролцоод хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд, тендерт шалгарахгүй бол нөгөө тендер шалгарсан байгууллагыг нь дарамталдаг, тендерт хамт орсон хувийн хэвшлийн компаниудаа дарамталдаг ийм нөхцөл байдалтай болсон байна. Энэ өнөөдрийн хэлэлцүүлгийн үр дүнд нөгөө өглөө би бас хэлэлцүүлэг хийчхээд ирж байгаа, ирж байгаа мэдээлэл.

3-д энэ 14 мега төсөл хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Нэлээн их хэмжээний бас мөнгө тавигдсан байгаа. Энэ 14-өөс бол яах вэ, хоттой холбоотой төслүүдийг нь бол ойлголоо. Одоо энэ сайд нь байх юм байна. Хотын дарга ингээд хэрэгжүүлээд явах юм байна. Бусад мега төслүүдийг яг хэн хариуцах вэ? Салбар хоорондын зохицуулалтыг нь яг хэн хийх вэ? Яг мега төсөл бүрээр нь мэдээлэл авмаар байна.

Яагаад гэхээр энэ чинь зөвхөн тухайн салбарын асуудал биш нэлээн олон салбаруудыг хамарсан асуудал байгаад байгаа юм. Бас зарим нь нэг нь бол манай дотоодын асуудал ч биш 2 хөрштэй холбоотой асуудлууд байгаад байгаа юм.

Тэгэхээр яг бодит байдлаар энэ 14-өөс яг хэд нь явах боломж бүрдсэн байгаа юм гэдгийг бас мэдээлэл авчихмаар байна.



Мөн энэ орон нутгийн янз янзын урамшууллын мөнгөнүүд их яваад байгаа юм. Одоо нөгөө сая Энх-Амгалан сайдын яриа үзэж байхад нийгмийн даатгалын сан 4 их наяд төгрөгийн алдагдалд орлоо гээд. Би 2023 онд малчны нийгмийн даатгалын асуудлыг эсэргүүцээд дийлээгүй л дээ. Яг түүнтэй адилхан маш олон хөтөлбөр хэрэгжиж байна.

Нийгмийн даатгалын сан нь дампуурч байна. Улсын төсвөөс сарлагийн хөөвөр, хонины ноос, сүү, ингээд бүр ерөөсөө тэр нэг нөгөө 5 хошуу малаас гардаг бүх юмыг нь урамшуулж байна. Тэгээд яг үр дүн нь яг юу байгаа юм бэ гэдгийг бас тодруулчихмаар байна.

Мөн сүүлийн үед хэсэг бүлэг нөхөд хүүхдэд 30 мянга төгрөг тараана гээд яваад байгаа юм. Тэр яг хаанаасаа гарч ирсэн 30 мянган төгрөг вэ гэдгийг бас тодруулчихмаар байна.

**Р.Сэддорж:** Хариулт Лувсаннъямын Гантөмөр сайд, микрофон нээе.

**Л.Гантөмөр:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчит компанийн менежментийг сайжруулах чиглэлээр бол ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Энэ ер нь судалгаанууд бол хийгдэж байгаа. Хараат бус байгууллагуудад судалгааны захиалга Засгийн газар өгөөд хагас жил болж байгаа юм байна лээ. Үүний үр дүнд бол компани бүр дээр тодорхойлолтууд гарч байгаа. Компани болгоны газрын зураг гарч байгаа.

Тэгээд таны хэлдгээр төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх, өрсөлдөж байгаа хэсгийг нь татах гэдэг энэ ажил бол хийгдэнэ.

Эрдэнэс тавантолгой компанийн 2,7 их наяд төгрөг зээлсэн асуудлыг Наранцогт миний хариултын дараа хариулна. Ялангуяа энэ цахилгааны, юу эрчим хүчний салбар дахь төр, хувийн

хэвшлийн оролцоо, зохицуулалт гэдэг зүйл бол манай Шадар сайдаар ахлуулсан Үндэсний хороо ажиллаж байгаа. Тэгээд ойрын үед бараг улсын төсөв батлагдахаас өмнө өөрсдийнхөө санал, дүгнэлтийг Засгийн газар болоод Их Хуралдаа танилцуулна. Тэр үеэр түгээх нь яг ямар байх юм, дамжуулах нь яг ямар байх юм, үйлдвэрлэгч нь яг ямар байх юм, хөрөнгө оруулалтын орчин нь ямар байх юм, үр бүтээмж нь ямар байх юм, ашиг нь ямар байх вэ гээд ингээд бүх тооцоолол бол гараад ирэх юм.

Тэгэхээр энэ төрийн компани хувийн хэвшилтэй өрсөлдөж байгаа зүйлийг бид нар бүрэн эрхийнхээ хугацаанд бүрэн таслан зогсоож байж, цаашаа эдийн засаг эрүүлжинэ гэдэгтэй бол санал нэг байгаа.

Бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр бид нар ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа. Үүнийг Эдийн засаг, хөгжлийн яам өөрөө удирдаад зохион байгуулаад явж байгаа. Тэгэхийн тулд бол манай дээр 3 дэд судалгааны ажил яг ид хийгдэж байна. Үнэхээр хаана нь асуудал байгаад байгаа юм бэ? Тэгээд гарсан судалгааны асуудал гараад ирэхээр би Эдийн засгийн байнгын хороондоо танилцуулна. Их Хурал дээр байгаа ажлын хэсэгтээ танилцуулна. Тэгээд хэдүүлээ судалгаагаа нэгтгэж байгаад ер нь ондоо багтаагаад 12 сарын 20-ноос өмнө Их Хурал дээр яг энэ бизнесийн орчноо сайжруулах, бизнес рүү төр халддаггүй байх, өмч рүү халддаггүй байх, бизнесийн эрх рүү халддаггүй байх, худалдаа руу халддаггүй байх тэр алхмуудыг хэдүүлээ эртхэн эхлүүлнэ. Ондоо багтаад энэ ажил эхэлнэ. 25 онд бол бодитой үр дүн гарсан байх ёстой л гэж харж байгаа, бодитой үр дүн. Үнэхээр данс хаахаа больчихлоо. Шууд аваачаад хорьдгоо больчихлоо. Мөнгө угаана гэж яг ийм гэмт хэрэг байдаг юм байна, түүнийг нь ангилаад өгчихлөө. Их тодорхой болгох хэрэгтэй. Тэгээд энэ тодорхой ажлуудыг хэдүүлээ хамтраад хийнэ. Энэ бол тал талаасаа хүчээ



нийлүүлж байгаад хийхээс өөр аргагүй нэлээн том сорилт байгаа. Яагаад гэвэл энэ бизнесийг дарамтлаад амьдардаг том тийм систем хүртэл байна. Тэр бол бодитой байна.

Тийм учраас бол үүний эсрэг нэлээн хүчтэй ажил хийхээс өөр аргагүй гэж ингэж харагдаж байна.

**Р.Сэддорж:** Хариулт дуусгах уу. Хариултыг үргэлжлүүлье, микрофон өгье.

**Л.Гантөмөр:** Ер нь энэ нийгмийн даатгал алдагдалд орлоо гэдэг нь тийм зохион байгуулалттай алдагдал оруулчихсан ч юм байхгүй л дээ. Тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн, хамрах хүрээ нэмэгдсэн, тэтгэвэр бодох аргачлал өөрчлөгдсөн, тэтгэвэр авч байгаа хэмжээ нь нэмэгдсэн учраас орж ирж байгаа орлого нь зарлагаа гүйцэхгүй байгаа. Илүүдэж мөнгө үлдэхгүй байгаа гэдэг ийм л ойлголт байгаа юм.

Тийм учраас харин хэдүүлээ энэ ер нь цаашаагаа энэ тэтгэврийн санг яах вэ, Ирээдүйн өв сангаасаа бид нар энэ тодорхой нийгмийн даатгалын хуримтлалыг хэрхэн бий болгох вэ гэдэг дээр маш тодорхой алхмуудыг хийх хэрэгтэй. Яг энэтэй зэрэгцүүлээд ХАА-н салбарт бол бид нар бараг жилд 1 их наяд төгрөгийн хөтөлбөр хэрэгжүүлээд, татаас өгөөд ингээд яваад байгаа шүү дээ. Гол зүйл бол би Хөдөө аж ахуйн яамтай ямар системийн нэгдэл бий болгох гэж байгаа вэ гэхээр үр өгөөж. Ерөөсөө л өгөөж, үнэ цэн, нэмүү өртөг, өрсөлдөх чадвар. Бидний бүтээгдэхүүн хаана өрсөлдөх вэ, ямар үнэ цэнтэй байх вэ. Тэрийг хэн худалдаж авах вэ. Энэ нь өөрөө Монголын эдийн засагт ямар ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариултуудаа гүйцэд авъя. Зээл олгосон асуудлаар Наранцогт дарга 4 номерын микрофон.

**С.Наранцогт:** Би зээл юм уу, өр төлбөр юм болов уу гишүүн, би нөгөө энэ сая Ганбаатар сайдтай юм ярьж байгаад таны асуултыг бол сонсоогүй юм байна.

Тэр нөгөө Эрдэнэс тавантолгой үндсэндээ Тавантолгой түши компани энэ төмөр замын санхүүжилт, хийн хоолойн санхүүжилт гэсэн ийм том төслүүдийн санхүүжилтийг хийж байгаа юм. Энэ санхүүжилтүүд бол зээлээр бүртгэгдээд явж байгаа.

Тийм учраас бид нар энэ сая Улсын Их Хурлын 10 дугаар тогтоолыг гаргахад бол Эрдэнэс тавантолгой дээр нэг талдаа ингээд авлагууд үүсээд байгаа, нөгөө талдаа хуримтлагдсан өр төлбөр нэмэгдээд байгаа. Тэгээд үүнээс үүдэлтэй ер нь бол энэ төрийн өмчийн компаниуд Эрдэнэс Монголын нэгдлийн компаниудын хооронд үүссэн өр төлбөрийг энэ төрийн ноогдол ашигтаа суутган тооцох тухай 10 дугаар тогтоол гаргасан байгаа. Тэгээд үүний хүрээнд бол бид нар энэ өр төлбөр, өр авлагыг суутган тооцож цэгцлэх ажил яг хийгдээд явж байна.

Тэр Тавантолгойгоос өгч байгаа зээл бол тэр Тавантолгой түши, саяын миний нэрлэсэн энэ Тавантолгой төмөр зам, нефтийн хоолой гэсэн энэ төслүүдэд олгогдож байгаа зээлийг тэгж баланс дээр тусгаж байгаа.

**Р.Сэддорж:** Гантөмөр сайдын микрофон өгье. Хариулт.

**Л.Гантөмөр:** Ганхуяг гишүүний 14 мега төсөл яг хэн хариуцаж байгаа юм бэ гэдэг асуултад хариулъя. Засгийн газар тодорхой төсөл болгон дээр ажлын хэсэг гаргаж байгаа юм. Нэг сайдаараа удирдуулаад. Жишээлбэл Гашуун сухайт, Ганц модыг холбох, төмөр замын холбох ажлыг ажлын хэсгийг Туваан сайдаар ахлуулаад ажиллуулахаар болж байгаа юм. Дэлгэрсайхан сайд нарийн бичгийн дарга

байна уу, дэд даргыг нь хийж байгаа. Ингээд энэ 2 хүн ойрын үед тэр хэлэлцээрийг Их Хурал болоод Засгийн газраар оруулж ирж шийднэ. Тавантолгойг цэвэр Чойжилсүрэн сайд хариуцаж байгаа. Чойжилсүрэн сайд ондоо багтаагаад Тавантолгойн станцыг эзэнтэй болгох үүрэг хүлээж байгаа юм. Энэ үүнийг Чойжилсүрэн сайд хариуцаж байгаа. Рона буюу бид нар тэр уран олборлох, боловсруулах гээд тэр төсөл, хөтөлбөрийг Учрал сайд ахалж байгаа. Учрал сайд ахлаад Туваан сайд дэд даргыг нь хийж байгаа байх. Энэ ажлын хэсэг бол хэлэлцээрээ эцэслэх шатдаа явж байна.

**Р.Сэддорж:** Ганхуяг гишүүн тодруулга, микрофон нээеб

**Х.Ганхуяг:** Нэмээд ярихад энэ Зөвшөөрлийн хууль гээд олон салбарыг хамарсан, салбар хоорондын зохицуулалттай ийм процессын хууль байдаг. Цахимжуулах асуудлыг маш тодорхой уг нь оруулсан байдаг. Эдийн засгийн хөгжлийн яам дээр кодчлоод цахимжуулах ажлыг хийнэ ээ гээд. Зогсонги байдалтай байна.

Хөрөнгө оруулагчдын санал, гомдлыг Эдийн засгийн хөгжлийн яам сар болгон Засгийн газраар оруулж хэлэлцүүлдэг байсан, бас зогссон байна. Наранцогт захирал аа, юу бол зөвхөн тэр том төслүүд биш байсан шүү. Маш олон төрийн өмчит компаниуд байсан, Багануур гээд, олон компани байлаа. Би нэрийг нь санахгүй байна. Гэхдээ энэ хоорондоо ингэж зээл өгөлцөж, авладаг асуудлыг бол таслан зогсоон барина. Нэг бол Их Хурлаар орж зөвшөөрлөө авдаг болмоор байна. Наадах чинь бол ард түмний баялаг шүү. Та нарын төсөв биш шүү гэдгийг би анхааруулмаар байна.

**Р.Сэддорж:** Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Тийм, ер нь тэгэхээр Эрдэнэс Монгол компани Эдийн

засгийн байнгын хороонд сардаа биш юм гэхэд улиралд 1 удаа ингээд тайлангаа тавимаар юм байна лээ. Үүнийг Эдийн засгийн байнгын хороо өөрөө мэдээд шийдэх хэрэгтэй. Бүр ийм байнгын хорооны тогтоол гаргаад байнга дуудаж сонсож байх ёстой юм байна лээ. Ингэж байж энэ компани өөрөө ил тод болно. Мөн Төрийн өмчийн хороогоо ч гэсэн байнга дуудаж юу хийж байгаа вэ, яаж байгаа вэ, ямар ажлын ард гарч байгаа вэ гээд ингээд байнга сонсож байгаасай гэж хүсэж байна, 1-д.

2 дугаарт, энэ Зөвшөөрлийн хуулийн асуудлыг өнөөдөр энэ сонсож байгаа Төрийн нарийн бичгийн дарга нар яаралтай нэг тийшээ болгоорой. Яг нэгдсэн байдлаар нэгдсэн шийдэл бол төсөв батлахаас өмнө Их Хуралд танилцуулагдах ёстой шүү. Их Хурлын гишүүд 9 сарын 1-нд яг үүнийг нэхэж байсан. Өнөөдөр сар болж байгаа. Зарим ахиц байна. Тэгэхдээ зарим нь үнэхээр удааширч байна. Мөн ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Дараагийн гишүүн Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

**О.Батнайрамдал:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө ярилцаж байна. Тэгэхээр орлого талаасаа аваад үзсэн ч гэсэн, ач холбогдол талаасаа аваад үзсэн ч гэсэн аж үйлдвэр, эрдэс баялаг, уул уурхайн салбараа ярихаас өөр гарцгүй. Гол орлого уул уурхайн салбараас орж ирнэ. Гадаадын хөрөнгө оруулалт, дахиад экспорт уул уурхай.

Тэгэхээр энэ дээр 2 асуулт байгаа юм. Нэг нь бол сая Ганбаатар сайд нэлээн хөндчихлөө. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилт. Тухайн үедээ энэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг бид нар 22 оны сүүлээр батлуулж байхад дараа жилийн 6 сарын 30-наас нь хэрэгжинэ гэсэн боловч тэр хугацаагаа хүлээхгүй, түр журам хүртэл бид нар

Засгийн газраас гаргаад энэ биржийн арилжааг анх эхлүүлж байсан. Тэгэхээр ямар ч байсан нэг жил хагасын хугацаанд бол уул уурхайн бүтээгдэхүүний биржээр чинь 15 их наяд төгрөгийн арилжаа хийгдээд нэлээн амжилттай болсон.

Тэгэхээр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилт талаасаа ч гэсэн дараагийн шатдаа зайлиггүй гарах ёстой гэж үзэж байгаа юм. 1 дүгээрт, бол мэдээж уул уурхайн бүтээгдэхүүний биржээр бүр төрийн бүх компанийн уул уурхайн компанийн бүх бүтээгдэхүүнүүд арилжаалагдах ёстой. Энэ бол заавал хэрэгжих ёстой.

2 дугаарт, бас энэ дараагийн шатад гарахын тулд бас нэг заалт одоо хүртэл яг биелэхгүй яваад байгаа нь биржийн арилжаа гэдэг бол өөрөө зохицуулалттай зах зээлийн арилжаа. Юу гэсэн үг вэ гэхээрээ энэ СЗХ-ны хяналт дор мэргэжлийн байгууллага арилжааг нь явуулдаг гэсэн үг л дээ. Тэгэхээр Эрдэнэс тавантолгой ч юм уу, Эрдэнэт ч юм уу, Монрос ч юм уу өөрсдөө очоод бирж дээр би үүнийгээ арилжаалъя гээд арилжаалчихдаггүй тийм ээ.

Тэгэхээр ер нь Америкийн жишиг, ер нь бүх орны жишигийг аваад үзсэн ч гэсэн биржийн арилжаа бол мэргэжлийн оролцогч буюу брокероор дамжиж явдаг тийм ээ. Тэгэхээр брокер бол өөрийнхөө төлбөрөө аваад, өөрсдийн бас даах эрсдэлээ даагаад, ингэж эко систем нь өөрөө бүрддэг. Тэгэхээр энэ зохицуулалт хэзээнээс эхэлж хэрэгжихээр байгаа вэ? Компаниуд ингээд л бүгд өөр өөрсдийн юмаа хийгээд эхлэхээр л тэгээд асуудал үүсдэгийг бид нар Эрдэнэс тавантолгойгоос харсан. Нэг мэдсэн Эрдэнэс тавантолгой бүх юмны компани болчихсон байсан тийм ээ. Тэгэхээр үүнийг 1 дүгээрт, асуумаар байна.

2 дугаарт, ер нь бол уурхайн салбараа бид нар аваад үзэхээр нүүрс, зэс

маш ойлгомжтой. Монгол Улсын орлогын бараг 80 хувийг нь дангаараа, төсвийн орлогын 80 хувийг нь дангаараа бүрдүүлж байна. Бас нэг потенциалтай салбар бол уг нь алт юм байгаа юм. Алт. Хайгуул талаасаа аваад үзсэн ч гэсэн, хөрөнгө оруулагч талаасаа аваад үзсэн ч гэсэн дэлхийн зах зээл дээр алт түүхэн хэмжээндээ үнэ нь 2600 хүрээд 1 дүгээрт явж байна.

2 дугаарт, бид нар алтны биет хэмжээг экспортыг аваад үзэх юм бол 2021 билүү, 22 онд санагдаж байна. Анх удаагаа алт тэрбум долларын босгыг давсан 3 дахь уул уурхайн бүтээгдэхүүн болж анх гарч ирж байсан. Тэрбум долларын босгыг давж байсан.

Тэгэхээр бид нар хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр ч гэсэн алт цэвэршүүлэх үйлдвэр барина гээд 14 мега төслийнхөө нэгд оруулсан. Алт цэвэршүүлэхийн тулд бид нар өөрөө алтаа хангалттай олборлох ёстой. Тэгэхээр алт хангалттай олборлохын тулд хайгуул хийгдэх ёстой, геологийн нөөцөө бид нар илүү цаашаагаа сайжруулах ёстой. Биет хэмжээг нь ингээд аваад үзэхээр би та бүхэнд статистик хэлж байна. Энэ 20 онд 30 тонны алт тушаагдаж байсан бол 21 21 онд 17,3, 19,7 сүүлийн 2 жил 11,7, 24 оны 9 сарын 26-ны байдлаар 11,9 гээд огцом буурчихсан яваад байгаа юм.

Тэгэхээр үүнээс бол уул уурхайн салбараас асуумаар байгаа юм л даа. Энэ алтыгаа бид нар ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Батнайрамдал гишүүнд нэг минут нэмж өгье.

**О.Батнайрамдал:** Тэгэхээр энэ олборлолтыг бид нар яаж цаашаага бодлогоор сайжруулах вэ? Нүүрс ямар ч байсан бид нар тэсрэлт хийгээд явж байна. Зэс ямар ч байсан Эрдэнэт, Оюутолгой маань явчихна. Одоо алтыг яах вэ? Энэ дээр маш цогц бодлого хэрэгтэй байна л даа. Тэгэхээр уул нь бол

маши их потенциалтай бид нар алт цэвэршүүлэх үйлдвэр алтгүйгээр, алт олборлохгүйгээр, алт олборлохгүйгээр алт цэвэршүүлэх үйлдвэр гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ дээр ямар бодлого баримталж байгаа вэ? Геологийн нөөцөө сайжруулах ёстой. Гадаадад ерөөсөө уул уурхайн салбар дээр бол хамгийн хөрөнгө оруулалтын таатай орчин бол алтан дээр гарчихсан байна шүү дээ. Үнэ нь түүхэн хэмжээндээ хүрчихсэн. Манайх чинь алтан дээр ч гэсэн маш их боломжтой нөөцтэй орон байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ямар бодлого барьж байгаа вэ гэсэн ийм 2 асуултыг асуумаар байна.

**Р.Сэддорж:** Хариулт Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Тийм. Тэгэхээр энэ биржээр уул уурхайн бүтээгдэхүүнээ худалддаг зүйл бол цаашаагаа тогтвортой явна.

Өнөөдөр Эрдэнэс тавантолгой дээр биржийн бус худалдаа 4 компани дээр байгаа. Тэр нь оптек буюу урьдчилсан хэлцлээр ажил хийлгэчихсэн ийм 4 компани байгаа гэж хүн болгон тийм мэдээлэлтэй байх. Үлдсэн бүх нүүрс биржээр зарагдаж байгаа. Бусад компанийн бусад бүтээгдэхүүнүүд ч гэсэн биржээр цаашидаа арилжаалагдаад явна. Зүгээр биржийн хөгжлөө яаж харж байгаагаа Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга тэр брокертой холбоотой юмнуудыг тайлбарлаарай.

Нөгөө талдаа ер нь алтыг дэмжих бодлогоо хэрэгжүүлнэ. Зүгээр алт маань хаачаад байна вэ гэдэг асуудал байгаа. Яг ковидын үед хил хаагдчихсан байгаа үед алтны олборлолт буюу алтны Монголбанканд тушааж байгаа алтны хэмжээ бол эрс сайжирсан. Хил нээсэн, Монголбанканд тушааж байгаа алтны хэмжээ бол багассан. Тоо тэрийг хэлж байгаа.

Нөгөө талдаа алт руу хөрөнгө оруулж байгаа хөрөнгө оруулалтаа дэмждэг тэр суурь бодлогууд холдсон байгаа. Бид ямар бодлого хэрэгжүүлэх гэж байгаа вэ гэхээр нүүрс, зэс одоо Монгол Улс цаашидаа өрсөлдөх хамгийн том хүчээ зэс дээр харж байгаа. Зэснийхээ борлуулалтыг бид нар нэг 5 тэрбум долларт хүргэхэд бол цаашаа улс орны эдийн засагт маш хүчтэй тийм суурь баталгаа болох юм байна гэж. Нөгөө талдаа алтныхаа олборлолтыг өнөөдөр байгаа энэ 20 тонн гэдэг түвшинээ цаашаа ахиулахыг зорино. Энэ бол бид нарын зорилго гэж хэлмээр байна.

Ганбат төрийн нарийн биржээ нэг жоохон тайлбарлах арга байна уу Ганбат байна уу. Ганбат даргыг 7 номерын микрофон дээр урьж байна.

**Ж.Ганбат:** Би нэмж тайлбар хэлье. Яах вэ, нөгөө Уул уурхайн биржийн тухай хууль батлагдаад 23 оны 2 сараас 7 сарын 1 хүртэл туршилтын байдлаар арилжаа хийсэн. 23 оны 7 сарын 1-нээс өнөөдрийг хүртэл биржийн тухай хуулийн дагуу арилжаа бол явагдаж байгаа. Тогтмол 7 хоног болгон. Яг зах зээлийн нөхцөлтэйгөө уялдуулаад яах вэ, нүүрсний компаниуд бол ямар чанарын нүүрс арилжаалбал ямар ашигтай байх вэ гэдэг. Жишээ нь сайн чанарын нүүрсний үнэ буурсан тохиолдолд сул коксжсон байна, эрчим хүчний нүүрсийг түлхүү зарах энэ тэр гэдэг өмнө нь явж байсан бодлогоос арай өөр бодлого нөгөө гаргасан бүтээгдэхүүнээ сорчлохгүй байна. Тэр энэ бодлоготойгоо уялдуулаад биржийн арилжаагаа зохион байгуулаад явж байгаа.

Биржийн тухай хууль дээр нэг заалт байгаа нь брокероор дамжуулна гэдэг ийм нэг заалт байгаа. Яг энэ брокерыг бид яаж хэрэгжүүлэх вэ ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Нэмж цаг өгье. Ганбат даргын 7 номер.



**Ж.Ганбат:** Брокер бол өөрөөр хэлэх юм бол компанийн өмнөөс худалдан авагч нар тэр бүтээгдэхүүнийг нь сурталчилж барих биржийн арилжаанд оролцохыг нь ингээж уриалах ийм зорилготой.

Тэгэхээр энэ дээр бас анхаарах асуудлууд байна. Өнөөдөр төрийн өмчийн компаниуд ялангуяа Эрдэнэс тавантолгой компани энэ тэр бол нэг 10 гаруй жилийн түүхтэй компани бүтээгдэхүүнээ заавал брокероороо дамжуулаад байх шаардлага байна уу, байхгүй юу. Нэг дэх нь.

2 дахь нь, тэр биржийн арилжаанд оролцож байгаа худалдан авсан компани нүүрснийхээ төлбөрийг брокероор дамжуулж төлнө. Тэгэхээр тэр брокерын дансанд жишээ нь 100 сая доллар орж ирэхэд тэр мөнгө яг түүгээрээ дамжаад жишээ нь тэр төрийн өмчийн компани байна уу, нүүрс харилцан компанийн данс руу орно гэсэн 100 хувийн баталгаа байна уу гээд бас юмнууд байна лээ.

Тэгэхээр энэ асуудал дээр бол ингээд тодорхой хугацаагаар үүнийг боловсронгуй болгох энэ асуудал дээр ярилцах энэ тэр гэсэн ийм асуудлууд бол яг Хөрөнгийн биржийн тэр брокерын асуудал дээр үүсээд байгаа.

Нөгөө талдаа бид яг энэ бирж дээрх ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Дахиад нэмж хариулья.

**Ж.Ганбат:** Нэмээд энэ биржээр зарагдсан нүүрсийг бид нөгөө хил нөхцөлөөр буюу Ганцмод нөхцөл дээр Ганцмод боомт дээр хүргэж өгөх үүрэгтэй. Энэ дээр хилийн нэвтрэлттэй асуудлууд бол байгаа. Бид нар биржээр арилжаалсан нүүрсийг худалдан авагч нарт бол яг тэр тогтоосон хугацаанд нь бол хүргэж өгөх үүрэгтэй. Энэ бол яах вэ, саяын энэ 7 сарын наадам болсон. Энэ

жил бол говийн аймгуудад бол бороо хур ихтэй элбэг байсан. Үүнтэй холбоотой.

Нөгөө талдаа БНХАУ-ын бас нэг энэ амралт энэ тэр таараад зарим юман дээр бол энэ нөгөө зуны яг энэ 7, 8 сарууд дээр бол жоохон буурсан асуудлууд бол байгаа юм байна лээ. Энэ бол гэхдээ яах вэ, тухайн үеийн улирлын чанартай ингээж бас жоохон саатсан юмнууд бол байна лээ. Нөгөө талдаа бид яаралтай энэ хилийн нэвтрүүлэх асуудлыг ер нь энэ биржийн арилжаатай уялдуулж яаралтай шийдэхгүй бол бирж дээр бол нүүрс ингээд гээд арилжаад хэвшчихсэн. Одоо гарах нь хилээр бид нэвтрүүлээд л тэр Ганцмод боомт дээр хугацаанд нь хүргэж өгөх асуудал дээр л бас онцгой анхаарах, энэ хилийн нэвтрэх чадвар ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Тодруулга нэг минутаа авчихсан байгаа тийм ээ. Дараагийн гишүүн Ганзоригийн Лувсанжамц гишүүн, микрофон өгье.

**Г.Лувсанжамц:** Эрхэм төрийн түшээдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Юуны өмнө энэ Монгол Улсын зээлжих зэрэглэлийг нэг шатаар ахиулсан. Мөн цахим засаглалыг 28 байраар урагшлуулсан салбар яамнууд болон хамтран ажилласан бүх төрийн албан хаагчдадаа баяр хүргэе. Цаашидаа бас тууштай ажиллаад илүү өндөр амжилт гаргана гэдэгт найдаж байна.

4 асуулт байна л даа. Даанч Хот байгуулалтын яам байхгүй байх шиг байна. Тэгээд Байнгын хороон дээрээ ирдэггүй юм бол тэгээд, ирчихсэн байна уу тийм ээ. Тэгвэл оролцуулаад 4 асуулт асуучихъя.

Эхний асуулт Эдийн засаг, хөгжлийн яам, Гэр бүл, хөдөлмөрийн, нийгмийн хамгааллын яам хамарсан асуулт байгаа. Энэ эдийн засгийг өсгөж, орлого нэмэгдүүлэх, дэд бүтцийг тэлэх, хөгжүүлэх, аж үйлдвэр, экспортыг



нэмэгдүүлэх ийм төслүүд 14 мега төслүүдийг бол дэмжиж байна.

Тэгээд миний хувьд сая ээлжит бус чуулганаар 28 он хүртэлх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн ажлын хэсэгт орж ажиллаад зарим өдөр шөнө 2 цаг хүртэл суусан л даа. Тэгээд ингээд 2025 оны хөгжлийн төлөвлөгөө ороод ирсэн чинь энэ 4 жилийн Засгийн газрын хөтөлбөртэйгөө уялдаагүй. Зарим заалт нь ороогүй. Албаар хассан юм уу яадаг юм, эсвэл ажил хиймээргүй байгаа юм уу мэдлэггүй ойлгомжгүй тийм зүйлүүд байгаад байна. Эд нарыгаа яах вэ гэдэг асуулт үндсэн асуулт байна.

Жишээлбэл байна шүү дээ, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1, 2.1.3 дээр гэр бүл нийгмийн баталгаа, 3.2.1 дээр болохоор татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх нийтдээ 7 заалт орсон байгаа шүү дээ. Тэгээд 25 оны хөгжлийн төлөвлөгөө дээр болохоор хоёрхон заалт ороод ирчихсэн. Тэгээд тэр 2 заалт нь их ерөнхий. Тэгээд даатгалын тогтолцоог үе шаттайгаар сайжруулна ч гэдэг юм уу тийм ээ, маш ерөнхий зүйл биш шүү. Энэ 25 ондоо юу хийх гэж байгаа нь ойлгомжгүй байгаад байна. Ажлын хэсэг байгуулах юм уу, зөвлөл байгуулах юм уу, олон нийтийн санал асуулгыг авах юм уу, тэр дундаа ажил олгогчдоос саналыг нь авах юм уу иймэрхүү ийм зардал төсөв их шаардахгүй хийж болох ажил зөндөө байгаа шүү дээ. Үүнийгээ хийнэ гээд 25 ондоо уг нь зорьчихмоор байх юм. Тэгээд ийм ажлуудаа төлөвлөгөөндөө бичихгүй бол тэгээд яаж ч хэлбэл зүгээр юм, ойлгохгүй л байна л даа.

Тэгээд одоогийн нөхцөл байдал бол нийгмийн даатгал нь өөрөө ингээд сайн сайхан ирээдүйн баталгаа биш ингээд өөрөө дарамт болчихоод байгаа шүү дээ. Үүнийгээ ингээд хурдан засахгүй бол ерөөсөө нийгэм тэр чигээрээ бүхмидалтай байгаа шүү дээ.

2 дахь асуулт. Эдийн засгийн хөгжлийн яам. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах журам батлагдсан. Танай яам өөрсдөө боловсруулж баталсан тийм ээ. Тэгээд ингээд хөрөнгө оруулалтын төслүүдээ дөвийлгөж тавьчихаад энэ төлөвлөгөө дээрээ, тэгээд хүрэх үр дүнгээ тодорхойлоогүй, шалгадаггүй байдлууд бас байгаад байна. Ялангуяа энэ төсвийн зардлын 80-аас дээш хувийг эзэлж байгаа энэ урсгал зардлаараа ямар үр дүнд хүрэх юм бэ гэдгийг тодорхой бичихгүй байна.

Ээлжит бус чуулганаар алсын зорилго, хүрэх үр дүндээ суурилоод төлөвлөх хэрэгтэй байна. Хөгжлийн бодлогын бичиг баримтаа зохиоё оо, бүгдээрээ хамтдаа нийлээд нэг зүг рүү харья гээд 2 ч удаа хэлсэн л дээ. Одоо тэгсэн чинь ингээд Алсын хараа 2050-ийн зорилт, шалгуур үзүүлэлтүүд, 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд, 25 оны хөгжлийн төлөвлөгөөний энэ шалгуур үзүүлэлт нь ингээд хоорондоо ондоо. Ингээд төлөвлөгөө зохиохдоо ингээд килограммаар тавьчихаад, үр дүнгээ хэмжихдээ метрээр хэмжинэ гээд ямар ч үр дүнд хүрэх боломжгүй шүү дээ энэ чинь. Жишээлбэл ингээд Солонгосыг харахад үндэстнээрээ ерөөсөө хоёр зуухан л зорилт тавьчихсан байгаа. Бүх яамнууд нь орон нутгийн захиргаа ч гэсэн энэ 200 зорилтдоо хүрье гээд түүнийгээ яг адилхан хэмжүүрээр хэмжээд, хүрч байна уу, үгүй юу гэдгийгээ ярилцаад урагшлаад хөгжсөөд яваад байгаа шүү дээ. Манайх тэгсэн чинь ингээд бүгдээрээ л тал тал тийшээ харчихсан. Бүх бодлогын бичиг баримт нь хоорондоо уялдаагүй ийм сонин байдал байгаад байгаа. Үүнийг яаралтай засах хэрэгтэй байна гэдэг зүйл байна.

3 дахь асуулт Сангийн яамнаас. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3.11 дээр Монголын ногоон санхүүгийн корпорацыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна гээд бичсэн боловч 25 оны хөгжлийн

төлөвлөгөө дээр байхгүй байна. Үүнийг байгуулах юм уу, хэзээ байгуулах юм. Энэ ондоо багтаад байгуулахгүй бол хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр байхгүй болно гэсэн тийм эрсдэл байгаад байгаа шүү.

Дараа нь Барилга, хот байгуулалтын яамнаас асуулт байгаа. Нэг минут сунгачих уу?

**Р.Сэддорж:** Лувсанжамц гишүүнд нэг минут сунгая. Гишүүд дуугаа аядаарай.

**Г.Лувсанжамц:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас бас асуулт байна. Энэ бас адилхан. Хөрөнгө оруулалт хэрэггүй. Ерөөсөө ингээд журам ийм янз бүрийн дүрмүүдийг л өөрчилчихөд иргэдийн амьдрах орчин сайжрах боломжтой ийм зүйл заалтуудыг, зорилтыг Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр дээр хэлж байж оруулсан. Нэгдсэн чуулган дээр маш олон гишүүд дэмжиж үүнийг оруулъя гээд санал нэгдсэн шүү дээ. 4.2.4.1 дээр. Энэ хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг олж оршин суугчид аж ахуйн нэгжийн саналыг харгалзан боловсруулаад, түүнийхээ дагуу бүтээн байгуулалтыг хийе гэж байгаа юм. Аж ахуйн нэгжээс санал авъя гэдэг чинь яагаад гэхээр одоо аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар борлуулалтын нэг хувийг хүртэлх орлогыг нийгмийн зам талбай сайжруулах, цэцэрлэгжих ажилд зарцуулах юм бол татварын хөнгөлөлт олгодог болсон ийм хууль батлагдчихаад байгаа шүү дээ. Үүнийгээ хэзээ ашиглаж эхлэх юм бэ гэдэг тийм асуулт байна.

**Р.Сэддорж:** Энэ хариулт эхлээд Гантөмөр сайдын микрофоныг өгье. Гантөмөр сайд.

**Л.Гантөмөр:** Яах вэ, бид нар хөгжлийн төлөвлөгөөгөө харахдаа 21-25 оны хөгжлийн төлөвлөгөө гээд Их Хурлаар баталчихсан их том баримт

бичиг байгаа. Тэгээд 21-25 оны хөгжлийн төлөвлөгөөндөө бид нар 1 дүгээрт захирагдаж байгаа юм.

2 дугаарт, 24-28 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр байгаа. Тэгэхээр 24-28 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр бол ирэх 4 жилийн хөтөлбөр. Энэ бол 1 жилийн хөгжлийн төлөвлөгөө гэж харж болно. Мэдээж Эдийн засгийн байнгын хороо бусад Байнгын хороо дээрээс ирэх жил үүнийг заавал оруулмаар байна гэсэн зүйлсийг бол нэмээд оруулаад явчхаарай. Яамнууд саналаа өгдөг. Ирэх жилдээ нөгөө 25 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөө дотор багтсан ажлуудаа дуусгахыг зорьж, саналуудаа өгсөн байх гэж бид нар бол бодож байгаа. Бид нар санаатайгаар хассан юм бол алга. Аль болохоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг амжилттай эхлүүлэх он жил бол 25 он байгаа.

Таны хэлж байгаа нөгөө хот төлөвлөлтийн хуультай холбоотой асуудал бол 2040 хотын ерөнхий төлөвлөгөөг бид нар энэ ондоо багтаагаад батлуулах зорилт дэвшүүлж байгаа шүү дээ. Засгийн газрын 100 хоногт багтаж Их Хуралд өргөн баригдахаар.

Нөгөө талдаа бол энэ төлөвлөгөө хийж байгаа компанийн гүйцэтгэл гэж бас нэг юм байгаа. Зүгээр бидний зүгээс шахаж шаардах зүйл бол тэр компанийн төлөвлөлтийн процесс дунд явал таны хэлдгээр аж ахуйн нэгж болоод мөн иргэд, оршин суугчдын хүсэл сонирхлыг шингээх вэ, тэр уулзалтуудыг хэрхэн зохион байгуулах вэ гэдэг ийм даалгавар байгаа. Энэ дээр Улаанбаатар хотын захиргаа, дээр нь Хот байгуулалтын яам энэ дээр анхаарч ажиллах шаардлага байна.

Хүрэх үр дүнтэй холбоотой бид нар үндсэндээ 600 орчим зорилтыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт баталсан. Ямар үр дүнд

хүрэх вэ гэдгээ их тодорхой гаргаж байгаа. Энэтэй холбоотой календарьчилсан төлөвлөгөө гарна.

Тэгээд таны хэлдгээр 600 ажил бол бид нар зорьж байгаа болов ч маш тодорхой 100 зорилгыг бол гаргах байх. Энэ бол яг Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө гэж батлагдах үед гарах зорилтууд гарна. Энэ нь чадвал бид олон улсын стандарт руу тэмүүлнэ. Тэгэхдээ бидний хийж чадах зүйлээ эхлээд маш тодорхой болгоод, түүнийхээ ард гараад, тэгэхдээ олон улсынхаа хандлага чиг баримжааг аваад явах ийм л зорилт байна.

Тэгэхээр та түрүүн хэлсэн, В+ гээд олон улсын үнэлгээ зээлжих зэрэглэл ахилаа гэдэг шиг бид бүх зорилтот түвшинээ ОУБ-ын шалгууруудад нийцүүлж гаргахыг л зорьж байгаа. Тэгэхээр манай зорилтууд зорилт болгон тэр олон улсын шалгуурын аль хэмжүүр лүү яаж тэмүүлж байгаа вэ гэдэг ийм төлөвлөлтүүд хийгдэнэ гэдгийг хэлье.

Тэгээд бусад өөр хэн хариулах билээ. Тийм, Нийгмийн хамгааллын яам.

**Р.Сэддорж:** Нийгмийн хамгааллын яам хэдэн номер байна. 9 номер. Өөрийгөө товч танилцуулаад.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга Хишигбаяр гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2024-өөс 28 оны хөтөлбөрт бол Хөдөлмөр, гэр бүл, нийгмийн хамгааллын яамны чиглэлээр бол 54 зорилт, арга хэмжээ бол яг тусгагдсан байгаа. Энэ 54 зорилт, арга хэмжээг бид нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөндөө бол бид нар илүү нарийвчлаад 54-өө задлаад бол хэрэгжүүлнэ гэж төслийг боловсруулаад явж байгаа.

Энэ удаагийн хөгжлийн төлөвлөгөөнд бол бид нар илүү 25 онд бид нар төсвийн төсөл дээрээ тусгасан арга хэмжээгээ илүү 25 оныхоо хөгжлийн төлөвлөгөөнд урсгаад явсан байгаа. Тэгээд тийм учраас бол энэ хөгжлийн төлөвлөгөө дээр манай яамны зүгээс бол гэр бүлийн цогц төвийг байгуулах, мөн нийгмийн даатгалын тухайд бол тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийг дэмжих төвүүдийг байгуулах, мөн гэр бүлийн биш хүн амын бодлогод хөдөлмөр ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт болсон уу? Сангийн яам ногоон санхүүжилт, ногоон зээлтэй холбоотой. Гантөмөр сайд хариулъя гэж байна. Гантөмөр сайдын микрофоныг өгье.

**Л.Гантөмөр:** Тийм, ирэх оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгаагүй шалтгаан бол энэ ондоо багтаагаад байгуулна. 25 сая ам.доллар-ын эх үүсвэртэй ногоон корпорацыг бид нар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэд бол байгуулахаар Засгийн газрын тогтоол гаргах саналууд яамдаас аваад явж байгаа. Энэ 25 сая долларын 5 саяыг нь бас Хөгжлийн банкнаас дайчилна гээд түүний эх үүсвэрийн тухай судалгаа хийгдэж байгаа шүү гэдгийг хэлье дээ.

**Р.Сэддорж:** Барилга, хот байгуулалтын яамнаас нэмж тайлбар өгөх байна уу? Гантөмөр сайд бас хариулчихсан. Микрофон дээр сууя. 9 номер.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны газрын дарга Баярбат Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Хот байгуулалтын салбарт хамгийн түрүүнд тулгамдаж байгаа асуудал бол бид нар энэ хууль, эрх зүйн орчны шинэчлэл гэж ингэж тооцож ажиллаж ирсэн. Ер нь Хот байгуулалтын тухай хууль бол 2008 онд

батлагдсан. Түүнээс хойш бид нар өөрчилж чадаагүй явж байгаа юм. Тэгээд энэтэй холбоотой хууль зүйн талаасаа хэрэгжилттэй холбоотой алдаа өөрчлөлтүүд бол нэлээн амьдрал дээр өргөн хэмжээтэй гарсан.

Тийм учраас бид нар олон улсын жишиг рүү хүрэх үүднээс хуулийн шинэчлэлийг хийж яваа. Тэгэхдээ бид нар бол Улсын Их Хуралд 2020 онд энэ шинэчилсэн найруулгын төслийг өргөн барьсан боловч 4 жилийн хугацаанд хэлэлцэж батлагдаж чадсангүй. Энэ нь бол гол нь Газрын багц хуулийг шинэчлэхтэй холбоотой нэлээн хүлээгдсээр байгаад ингээд хойшилчихсон.

Тэгэхээр одоо яамны хувьд бол хамгийн тэргүүлэх чиглэл энэ 25 оны хөгжлийн төлөвлөгөөнд ч гэсэн бид нар бас тусгаад явж байна. Энэ хуулийн шинэчлэлүүдийг багцаар нь нэлээн өргөн барья гэж байгаа. Хот байгуулалтын хуулиас гадна Ногоон байгууламжийн тухай хууль ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт нэмэх үү? Хариултыг нэмье.

**Ц.Баярбат:** Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх хуулиудыг бол одоо барьж хэлэлцүүлж батлуулна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Энэ дээр ер нь бол Хот байгуулалтын яам бол дээрээсээ биш доороосоо чиглэлтэйгээр бид нар явах ёстой. Тийм учраас олон нийт, иргэд бусад оролцогчдын оролцоог бий болгох энэ нөхцөлийг бол хуульдаа суулгаж өгч байж хэрэгжүүлэхгүй бол дүрэм журмын хүрээнд бол хэрэгжих хангалтгүй байгаа. Ийм талтай байгаа. Судалгаа шинжилгээнүүд бол манай яам дээр хийгдсэн байгаа учраас хуулийн төслийг боловсруулах явцад тантай бас хамтран ажиллах болно. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Тодруулга  
Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Товч бөгөөд тодорхой нарийн хариулсанд баярлалаа. Гантөмөр сайд 100 зорилт тавиад тэндээ ингээд хүрэхээр ажиллаж байгаа гэдэг нь бол их таалагдлаа.

Тэгээд ер нь бол яг Алсын хараа 2050-ийнхаа энэ зорилтууд, хүрч байгаа зорилгуудыгаа яг ингээд тодорхой тавьчихаад түүндээ яг хаана хүрээд байгааг нь ингээд Байнгын хороо ч юм уу тийм ээ, чуулганаар хэлэлцээд яваад байвал зүгээр болов уу гэж бодож байна. Хот байгуулалтын яаманд ч гэсэн баярлалаа.

4.2,4.3, 4.2,4.4 гээд заалтууд бас байгаа шүү, тэрийгээ анхаараарай. Иргэдийн оролцоо чухал гэж бас байгаа тийм ээ. Түүн дээрээсээ нэмээд тэр бол маш чухал. Мэдээж. Дээрээс нь нэмээд манай энэ төлөвлөгөө хоорондын уялдаагүй байдал маш их байгаа шүү дээ. Зам тээвэр нь нэг тусдаа төлөвлөгөө зохиочихдог, орон сууц нь тусдаа, дэд бүтэц нь тусдаа, хотын хөгжил нь тусдаа, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь бас ингээд дагадаггүй, газрын төлөвлөгөө нь бас тусдаа. Тэгээд ингээд газрын наймаа цэцэглээд байдаг гэсэн асуудлууд байгаа болохоор ажлын төлөвлөгөөндөө нарийн тусгаад энэ зүйлүүдээр ямар зүйл ажил хийхээ бичиж орж ирэхийг хүсэж байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Дараагийн гишүүн. Мандхай гишүүн нэг асуулт асуух гишүүн дээр нэмье. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн.

**М.Энхцэцэг:** Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө дээр эрчим хүчтэй холбоотой нийт 24 төсөл байна. Эдгээр төслийн ердөө 3 төслийг бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ. Бусад 21 төслийг гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлнэ гэж тусгасан байна. Тэгэхээр эндээс юу уншигдаад байна вэ гээд тэгэхээр бид



ерөнхийдөө гадаадын зээл, тусламжийг горьдоод л суусаар байгаад л ер нь өвөлдөө хэрэглэгчээ цахилгаан дулаанаар хангаж чадахгүй, хөлдөөхөд тулах юм байна гэсэн дүр зураг харагдаж байна.

Гадаадын зээл, тусламжийг бүтээхэд олж авахад ямар их цаг хугацаа ордог билээ гэдгийг хүн болгон мэдэж байгаа. Гэтэл бүх эх үүсвэрийнхээ төслүүдийг гадаадын зээл, тусламжаар хийнэ гээд тусгачихаар бид нар яаж эрчим хүчнийхээ эх үүсвэрийн дутагдлаас гарах юм бэ? Мэдээж том хөрөнгө оруулалттай томоохон эх үүсвэрийн төслийг гадаадын хөрөнгө оруулалт, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж болно. Гэтэл ядаж бага оврын ганц 2 эх үүсвэрийн төслийг улсын төсвөөрөө хэрэгжүүлж болдоггүй юм уу? 10мвт-ын нарны станц батарейтай хамт үсрээд л нэг 15-16 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай байж болж байна. Хувийн хөрөнгө оруулалтаараа бараг гадаадын зээл, тусламжаар бараг улсын төсвөөрөө ч гэдэг юм уу, ер нь бүх л боломжоороо бид нар эх үүсвэрээ барьж байж л эх үүсвэрийн дутагдлаас гарна. Одоо ингээд Арвайхээр, Баянхонгор, Өвөрхангай гээд гээд 110 киловольтын ганцхан хэлхээтэй, насжилт өндөртэй шугамаар тэжээгддэг ийм аймгууд байдаг. Энэ шугамууд дээр нь засвар хийхэд, энэ шугамууд нь өвлийн улиралд ганц тулгуур зогсоход л бүхэл бүтэн аймгууд маш олон сумууд хөлдөх хэмжээнд ийм хүрэхээр найдваргүй цахилгаан хангамжтай байгаа. Гэтэл энэ аймгийн төвүүдээр нэг 15-16 тэрбум төгрөг зарцуулаад нарны эх үүсвэр батарейтай нь барьж болохгүй юм уу, улсынхаа төсвөөр. Бид нар алийн болгон тийм ээ, гаднын зээл тусламжийг горьдож суусаар байгаад байна. Эх үүсвэрийн дутагдлаас гаргана гээд л танилцуулга уншихаар аягүй том зүйлүүд байгаа. Гэтэл ингээд юуг нь яг доторх төлөвлөгөөг нь харахаар ерөөсөө бүх эрчим хүчний төслүүдийг нөгөө цахилгаан дамжуулах түгээх шугамыг

барих төслүүдийг ч хүртэл гадаадын зээл тусламж гэгчихсэн.

Тэгсэн мөртөө замдаа болохоор бүр хэдэн тэрбум, хэдэн их наядаар нь ингээд зарцуулахаар ингээд тусгачихсан. Ингээд дүр зураг харагдаад байгаа. Тэгэхээр миний тавьж байгаа асуулт болохоор ядаж Тэрэлж рүү жишээ нь ингээд л 200 тэрбумаар зам тавина л гэж байгаа байхгүй юу. Тэгтэл энэ чинь бараг арваад нар салхины станцуудыг аймгийн төвүүдээр барьж, цахилгаан хангамжийг нь найдваржуулах тийм боломж харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг ингэж хэрэгжүүлж болдоггүй юм уу?

2 дугаар асуудал болохоор мөн нөгөө Лувсанцэрэн гишүүнтэй яг адилхан. Хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр дээр маш олон ажлууд ингээд тусгагдсан. Тэгтлээ нэг их хөрөнгө зарцуулахгүйгээ хэрэгжүүлж болмоор. Тэгсэн мөртөө энэ 25 оны хөгжлийн төлөвлөгөө дээр тусгагдаж орж ирээгүй. Тухайлбал 3.3.38 гээд цахилгаан хангамжаас үүдэлтэй гал түймэр, цахилгаан гүйдэлд хүн цохиулах тэр эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгоно гэсэн заалт ингээд л орж ирээгүй.

Тэгэхээр сүүлийн жилүүдэд та бүхэн мэдэж байгаа. Цахилгаанаас үүдэлтэй гал түймэр маш их гарч асар их хэмжээний хөрөнгө, санхүүгийн хохирлыг ард түмэн амсаж байгаа. Хүн цахилгаанд цохиулж, хүүхэд цахилгаанд цохиулж нас бару байгаа. Тэгэхээр Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам ингээд цахилгаанд цохиулах нь бидэнд хамаагүй, манай ажил биш гээд ингээд суух гээд байгаа юм уу. Тэгтлээ хөрөнгө зарцуулахгүй хийж болохоор ажлуудыг яагаад энэ хөгжлийнхөө төлөвлөгөөнд тусгаж орж ирэхгүй байгаа юм гэдгийг гайхаад байна. Олохгүй байна л даа.



Дараагийн асуудал нь мөн адилхан хөгжлийн төлөвлөгөө дээр хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө дээр 3.3.30 гээд эрчим хүчний системийн тогтворжилт, сэргээгдэх эрчим хүчийг зөв зохистой хөгжүүлэх бодлогын бичиг баримтыг боловсруулах, энэтэй холбоотой тогтолцоог бий болгох гээд л заалт байсан. Тэгээд мөн энэ дээр тэтглээ их бас хөрөнгө зарцуулчихгүйгээр хийж болох ажил. Бас л энэ хөгжлийн төлөвлөгөө дээр орж ирээгүй. Тэгэхээр үүнийг бүр ингээд гайхаад олохгүй байна л даа. Эсвэл Эрчим хүчний яам оруулж ирдэг юм уу, эсвэл Эрчим хүчний яам оруулж ирснийг нь Хөгжлийн яам нь хасчихдаг юм уу. Эсвэл тэр тогтвортой ажиллах нь бид нарт хамаагүй гээд суугаад байгаа юм уу? Би бүр ойлгохгүй л байна л даа.

Тэгэхээр энэ 3 асуултад хариулт авъя.

**Р.Сэддорж:** Эрчим хүчний яамнаас хүн ирсэн үү. Байхгүй байна уу. Гантөмөр сайд хариулах уу? Гантөмөр сайдын микрофоныг өгье.

**Л.Гантөмөр:** Ганбат дарга эрчим хүчний ирэх оны төсвийн мэдээллийг нэг товчхон хийчхээрэй.

Ер нь бид нарын барьж байгаа байр суурь бол эх үүсвэр талаа хувийн хэвшилээр хийлгэе гэдэг ийм байр суурьтай байгаа. Тийм. Түүн дээр бас манай гишүүд ойлгохыг хичээгээрэй.

Тэгээд энэ жилийн хувьд бол, ирэх жилийн хувьд бол бид нар дамжуулах шугамынхаа чадлыг сайжруулах, ер нь дамжуулах тал дээрээ Засгийн газар илүү хөрөнгө оруулалтаа хийгээд явах нь зөв байна гэсэн ийм ойлголттой байгаа юм. Тэгэхдээ мөнгө төгрөг илүү гараад боломж бололцоо байвал эх үүсвэр барилгүй яах вэ. Тэр бол тодорхой. Хувийн хэвшилтэйгээ хамтраад төр, хувийн хэвшлийн түншлэлээр асуудлуудаа

ингээд ойрхон ойрхон шийдээд явах боломжийг бид эрэлхийлж байгаа.

Нөгөө талдаа бодлогын шинжтэй эрчим хүчний салбарын шинэчлэлийг хийх ажил дээр мэдээж Энхцэцэг гишүүн манлайлж байгаа. Тэгээд гишүүн маань яг энэ хэлэлцүүлгийн явцад бас яг ирэх жил энэ энэ асуудлыг заавал хийлгэнэ гэсэн ажлуудаа ирэх оны хөгжлийн төлөвлөгөө дээр оруулаад явчихвал их сайн байна. Тэгээд зарим нэг зүйл дутуу орж ирж байгаа бол уучлалт хүсье.

**Р.Сэддорж:** Ганбат дарга 7 номер.

**Ж.Ганбат:** 2025 оны улсын Улсын Их Хуралд өргөн барьсан төсвийн төсөл дээр эрчим хүчний салбарт Эрчим хүчний сайдын хөрөнгө оруулалтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 610,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт гэхээр гадаадын ажил тусламжаар 7,3 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт гээд нийтдээ нэг 7,9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг эрчим хүчний салбарт 2025 онд хэрэгжүүлэхээр ингэж бол тусгасан байгаа. Энэ хөрөнгө оруулалт эрчим хүчний хүчин чадал, эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх энэ чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалт байгаа байгаа.

**Р.Сэддорж:** Микрофон, хариулт нэмэх үү, болчхов уу.

Эрчим хүчний яамнаас хүн байхгүй тийм ээ, байхгүй юу. Энэ манай Байнгын хорооны ажлын албаныхан анхаараарай. Эрчим хүчний яам бол заавал байх ёстой.

Тэгээд энэ үйл ажиллагааны 4 жилийн төлөвлөгөө хэлэцэж байхад маш хөшүүн байсан, Эрчим хүчний яам. Тэгээд энэ тариф, бид нарын энэ өнгөрсөн хугацаанд зохицуулаагүй ийм олон жил явчихсан. Тэгээд гадаадын хөрөнгө оруулалтаар ороод ирчихсэн тэр сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг гацаагаад, гэрээг нь хийж өгөхгүй ингээд

хойшлуулаад, тэгээд ийм тарифын асуудал байгаа юм бол ингээд эртхэн шийдэх боломж байхгүй байсан юм болов уу.

Одоо Эдийн засгийн хөгжлийн сайд Герман улс руу айлчлал хийх гэж байгаа. Ерөнхий сайд саяхан 2 жилийн өмнө байна уу, 1 жилийн өмнө очсон, Германд. Германы Ерөнхий сайд тэр Өмнөговь аймгийн Ханбогд сумд байгаа сэргээгдэх эрчим хүчний төслийг зогсоогоод байгааг бүр албан ёсоор хэлсэн. Үүнийг шийдэж өгөөч ээ. Тэгээд энэ дээр маш санаачилгагүй байна л гэж үзээд байна.

Тэгээд яах гэж сэргээгдэх эрчим хүчийг тэгвэл дэмжинэ гэж энэ өдий хүртэл ярьсан юм. Яах гэж гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж ирье гэж яриад байгаа юм. Тэгээд орж ирсэн хөрөнгө оруулалтыг ингээд хамгаалж, дэмжихгүй салбарынх нь яам байна гэхээр би бол ёстой ойлгохгүй байгаа юм. Энхцэцэг гишүүн ч ойлгохгүй байгаа.

Тодруулах юу байгаа юм, энд тэмдэглүүлэх үү, протоколд. 1 минут авах уу? 1 минут Энхцэцэг гишүүн.

**М.Энхцэцэг:** Эх үүсвэрүүдийг бүгдийг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар биш зөвхөн зээл, тусламжаар, хувийн хөрөнгө оруулалтаар гэдэг бодлого чинь бас яг тэтгэлээ зөв гэж бодохгүй байна л даа. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ч, гадаадын зээл тусламжаар ч, улсын төсвөөрөө ч барих шаардлагатай. Яагаад гээд тэгэхээр бид нар мэдэж байгаа шүү дээ. Гадаадын зээл тусламжийг олоход ямар их хугацаа билээ. Нөгөө 4 жил чинь тэгээд л дороо дуусчихна. Нөгөө л эрчим хүчний дутагдал чинь тэр чигээрээ л байна. Эрчим хүч бүр ямар аймаар хүнд байдалд орчихоод байгааг хүн бүхэн ойлгож байгаа шүү дээ. Бид нар ноднин өвөл хэрэглэгчээ тасалж байсан. Одоо эдийн засгийн өсөлттэй холбоотой жилд бараг

200мвт-аар өсөж байна. Хувийн хөрөнгөөрөө ч барь, тэр гаднынхаараа ч барь, улсынхаараа ч бас барих хэрэгтэй шүү дээ. Хамгийн хурдан хэрэгжих боломжтой хөрөнгө оруулалт чинь улсын төсөв шүү дээ.

Тэгэхээр ядаж нэг 200 тэрбумаар зам барьж байхын хооронд 20 тэрбумаар нарны станц батарейтай нь аймгуудаар барь л даа. Баянхонгор аймаг, Арвайхээр, Архангай аймаг, Арвайхээр бол бүр маш хүнд байдалд байсан шүү дээ. Сая очиход ингээд л тасарчихсан байгаа байхгүй юу.

**Р.Сэддорж:** Протоколд тэмдэглүүлээ. Төрийн өмчийн нүүрсний уурхайнуудтай, орон нутгийн өмчийн уурхайтай 1, 1 станц барих эрхийг нь бараг өгчихөөр юм даа. Ингэж эрчим хүчгүй зовж байснаас.

Дараагийн гишүүн  
Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн.

**М.Бадамсүрэн:** Энэ эдийн засгийн ирэх 4 жилийн нийгмийн хөгжлийн гол асуудал хэлэлцэж байгаад салбарын сайд нар яагаад ороогүй юм бэ гэдгийг Байнгын хороон даргаас асууя. Зарим сайд нар манай зүүн бүсэд гэхэд Барилгын сайд орон нутгийн сонгуулийн ажлаар явж байгаа юм байна лээ. Тэгээд бид бол улс орныхоо ирэх 4 жилийн хөгжилд санаа зовоод ингээд бүгд суугаад хэлэлцэж байдаг. Тэгээд салбарын сайд нар нэг ч байхгүй байгааг асууя, 1.

2-т нь, хөгжлийн төлөвлөгөөнд энэ орон нутгийн аймгийн Засаг дарга нарын саналыг ер нь хэр авч тусгасан бэ? Энэ парламентад аймгийн Засаг даргаар ажиллаж байсан олон хүмүүс гишүүнээр сонгогдсон.

Дараагийнх нь хөгжлийг тэтгэх дэд бүтцийн ялангуяа авто замын ажлууд бүх бүсүүдэд хийгдэж байгаад бол их баяртай байгаа. Яагаад гэвэл энэ

бол төрөөс хийх ёстой угаасаа л нийтийн эрх ашигт нийцсэн хөгжлийг дэмжих гол ажил. Эдийн засгийн яамны сайдаас асууя. Шадар сайдаас, Тэргүүн шадар сайдаас. Тус яамны гол ажил бол энэ эдийн засгийн шалтгаан нөхцөлийг зөв тогтоохоос эхлэх байх гэж би бодож байгаа.

Ер нь үнийн өсөлт яагаад байгаад байгаа юм. Ялангуяа орон нутагт хүнс, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт бол маш өндөр байгаа шүү дээ. Тэгээд энэ ер нь яг тээвэр логистикоосоо болоод байгаа юм уу. Эсвэл энэ хөнгөлөлттэй зээл байхгүйгээс болоод банкнаас өндөр хүүтэй 20 хувийн хүүтэй зээл авснаас болоод энэ жижиг дунд үйлдвэрлэл чинь, өрхийн аж ахуй чинь суманд дэлгүүр хоршоо энэ бүх юмны чинь үнэ өсөөд байгаа юм уу. Үүнийг яг судалсан зүйл байна уу?

Барилгын яамнаас Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны сайд нь ч байхгүй, төрийн нарийн ч байхгүй байгаа юм байна гэж ойлголоо. Уул нь асуух аягүй том юм байна. Энэ орон сууцын үнийн өсөлтийн шалтгааныг ер нь тооцож байгаа юм уу? Ингээд зах зээл өөрөө зохицуулна гээд орхичих юм уу? Яаж залуучууд чинь орон сууцтай болох юм бэ? Яаж энэ өндөр банкны хүүгээр ипотекийн зээл байгаа ч гэсэн яаж урьдчилгаа мөнгөө төлөх юм бэ? Энэ дээр нөгөө л аягүй бол тэгээд л барилгын материалын үнэ өссөн гээд тайлбар хийх байх л даа. Тэгээд газар олголтын асуудал энэ дээр бас уялдаж гарна. Газар олголтын Газрын тухай хуульд өөрчлөлт орвол яаж хялбарчлах юм бэ?

Түрүүн би чуулган дээр бас Гантөмөр сайдаас асууж байсан. Ер нь бол энэ Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 5 га газрыг хоршооны дунд үнэ төлбөргүй өгч байгаа шүү дээ. Тэгээд энэ шиг ийм тодорхой нөхцөлтэйгөөр тодорхой зориулалтын дагуу буцаад цаашид гадаадын иргэнд зарж

борлуулахгүй гэдэг юм уу, өөр зориулалтаар ашиглахгүй гэдэг юм уу ийм нөхцөлөөр энэ иргэдээ ер нь газартай болгох талаар яаж анхаарах юм бэ. Монгол Улсын ерөнхий сайд хэлсэн шүү дээ. Монгол өргөн уудам нутагтай, бараг нэг хүн нэг уулын дээр эзэмшээд амьдрах боломжтой гэж. Тэгээд энэ газраа хэзээ эдийн засгийн эргэлтэд оруулах юм бэ. Зөвшөөрлийн тухай хууль гээд мундаг хууль баталсан гээд яриад байгаа. Цахимжуулсан сайн, зөв. Гэхдээ ямар хүндрэл үүссэн гэхээр тусгай зөвшөөрөл авахад 30м2 гэж байсныг 40, 50, 60 болгоод нэмэгдүүлчихсэн шүү дээ. Тэгээд СУ гээд дэлгүүр байна. Энэ нэг бага метр квадратад л бүх л оронд ингээд л худалдаа арилжаа хийгээд болдог шүү дээ.

Тэгээд л нэг том стандарт тавиад л эрх зүйн байдлыг нь дордуулаад л. Тэгээд л энэ хүндрэлтэй зүйлүүдийг хэзээ арилгах юм бэ? Нэг их гоё хууль баталлаа гэж яриад ард нь аж ахуй эрхлэгчдэд үнэхээр хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна. Заавал том болохыг бид нар том метр квадраттай тансаг хэрэглээг дэмжихгүй гэдэг байр суурьтай л байдаг биз дээ, ер нь. Тийм ч учраас ипотекийн зээл чинь метр квадрат заачихсан байгаа шүү дээ, орон сууцын. Тэгээд үүнийг хэзээ өөрчлөх юм бэ? Ер нь бол дүгнээд хэлэх юм бол энэ засаглалыг сайжруулах ёстой болохоос биш ингээд хуулиа чангалаад л, засаглал дээрээ алдаа гарангуут хуулиа чангалаад л тэгээд л энэ нь сайн хууль болсон гээд л ингээд л олон нийтэд яриад л, тэгээд энэ бол ийм болохгүй байна.

Хамгийн сүүлийнх нь хөнгөлөлттэй зээлээр болон газар олголтоор л хувийн хэвшлийг дэмжих ёстой. Энэ зах зээлийн эдийн засагт. Дэд бүтцийг бол төрөөс маш сайн хийж байгаа юм байна. Би бол энд бол баяртай байна. Яагаад гэвэл бараа бүтээгдэхүүний үнэ буурна, барилгын материалын үнэ буурна. Тэгээд энэ зүйл дээр би тодорхой хариулт яг точный

авмаар байна. Барилгын яам ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** 10 сарын 15-наас өмнө бид нар 25 оныхоо төсвийг батлах ёстой. Бид нарын өнөөдрийн хэлэлцээж байгаа зүйл бол 6 сарын 1-ний дотор баталчихсан байх ёстой юмыг ингээд дараа нь баталж байгаа байхгүй юу. Тэгээд энэ хариуцлагыг хэн хүлээх юм, ер нь.

Өнөөдрийнх бол Ерөнхий сайд, эс үгүй бол түүний томилсон Засгийн газрын гишүүн Байнгын болон нэгдсэн хуралдаанд жилийн төлөвлөгөөний төслийг танилцуулна гэж байна. Ингээд Гантөмөр сайдыг томилж явуулсан гэж ойлгож байгаа. Сайдууд ирээгүй байна. Өнөөдөр хэлэлцээж эхлэхгүй бол 15-нд бол төсөв батлагдаж ч амжихгүй болно.

Ийм учраас өнөөдөр дараагийн хуралдаанаас эхлээд энэ сайдууд байхгүй асуудлуудыг шууд хуралдаан хойшлуулъя. Бадамсүрэн даргын сая Ганбаатар дарга ч хэлсэн, Байнгын хорооны дарга байсан хүн. Сая Бадамсүрэн гишүүн хэллээ. Ингээж шийдье. Чуулганд эрх биш ирэх байлгүй дээ.

Гантөмөр гишүүн, Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Яах вэ, бид нар бас дөнгөж чуулган эхэллээ. Тэгээд хуралдаанд хэн хэн орох вэ, яах вэ, ийх вэ гэдэг менежментийн юман дээр алдаж байж магадгүй. Жишээлбэл, яг Төсвийн байнгын хороо тэнд Эдийн засгийн хөгжлийн сайдаа нэхээд л бас яг та хэд шиг уурлаад л сууж байна.

Ер нь энэ сонгуулийн жил учраас хөгжлийнхөө төлөвлөгөөг намар луугаа л үлдээчихсэн л байхгүй юу. Тэгээд бид нар хэлэлцээж байгаа. Энэ дээр ч гэсэн Сэдээ дарга нэг их бухимдаад байх шаардлага бол байхгүй. Хамгийн гол нь энэ хөгжил төлөвлөлтийн хуулиа бариад л хөгжлийн төлөвлөгөө, хуучин бид нар Их Хурал

дээр үндсэн чиглэл гэж баталдаг байсан юм. Тэгээд үндсэн чиглэл нь арай эрт гардаг, араас нь дагаад төсөв төлөвлөгөө нь орж ирдэг төсөв нь орж ирдэг. Ийм л дэгтэй шүү дээ. Энэ дээр бол аймгууд саналаа өгөлгүй яах вэ. Аймгууд саналаа өгнө. Аймгийн дарга нар саналаа өгнө. Аймгийн дарга нар өөрсдөө 25 оныхоо төлөвлөгөөг баталж байгаа. Манай яаман дээр ирнэ, хянуулна, өөрсдийнх нь төлөвлөгөөнд бид нар бас оролцоно, тусална, санал өгнө. Харилцаа уялдаа байгаа.

Үнийн өсөлт ковидын үеийн өсөлт гэдэг зүйл, хамгийн өндөр өсөлт бол ковидын үед авсан. Тэр бол яалт ч байхгүй зам, тээврийн хил хаасан. Тийм ээ, хил хаасан, бараа ирдэггүй. Хил дээр бараа бөөгнөрсөн, дэс дараалал үүссэн, энэтэй холбоотой үнийн өсөлт бол дараа жилийнхээ өсөлтөд хадгалагдаж байгаа. Энэ зүйл ганцхан Монголд биш байна. Дэлхий даяараа үнийн өндөр өсөлт хадгалагдаад байна. Хэзээ буух вэ гэдэг ийм хүлээлт байна. Тэр хооронд бизнесүүд зогссон, зогссон учраас маш их алдагдалд орсон. Алдагдалд орно оо гэдэг нь яг хөрөнгийн алдагдалд орж байгаа. Таны хэлж байгаа мөнгөний бодлогын алдагдалд орж байгаа гэж ойлгож болно. Энэ зээлийн хүүгээ эргээж төлнө. Зээлийн хүү зогсоогоогүй, бизнесүүдийг яг тэр бизнесийнх нь мөнгөн утгаарх дэмжлэг бол харьцангуй бага байсан. Айл өрхүүдийг ковидын үед дэмжсэн. Тэр утгаараа компаниуд өнөөдөр шууд буцаагаад ковидын өмнөх шигээ үнээ бууруулах зүйл байхгүй байгаа.

Энэ онд харин тийм онцгой өсөлт бол байхгүй шүү. 24 оны нийт инфляц нэг 6; 6,5 хувьтай гарна. Тэгээд өнгөрсөн жилтэй харьцуулахад. Дараа жил ч гэсэн бид нар 25 ондоо бид нар инфляцаа бас 6 хувьтай болов уу л гэж харж байгаа юм. Ер нь энэ Монголын өөрийнх нь инфляцын үндсэн шалтгаан бол яг хөрөнгийн хомсдол шүү дээ. Хомсдол, валютын хомсдол, валютын хомсдолтой холбоотойгоор, төгрөгийн ханштай



холбоотойгоор л Монголын инфляц явдаг. Нэг үгээр хэлбэл бид нар валютынхаа нөөцийг 10 тэрбум доллароос дээшээ давуулчихсан үед энэ дотоод төгрөгийн ханшийн уналтаас шалтгаалсан юм ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Барилга хот байгуулалтын яам 9 номер.

**Ц.Баярбат:** Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Сайдын хувьд бол өнөөдөр Засгийн газрын хуралдаанд суусан. Тэгээд одоо яаман дээр ажиллаж байна. Төрийн нарийн бичгийн даргын хувьд бол яамны хэрэгжүүлж байгаа Төв цэвэрлэх байгууламжийн төсөл, Солонго 1, 2 орон сууцын төслүүдтэй талбай дээр ажиллаж байсан учраас саяын хугацаанд арай амжиж ирж чадалгүй түгжрэлд орсон гэсэн ийм үүднээс би өнөөдрийн хуралд оролцож байна.

Ер нь орон сууцын үнийн өсөлт бол тодорхой хувиар ажиглагдаж явж байгаа, 10 гаруй хувийн үзүүлэлтийг сүүлийн үеэр үзүүлсэн байгаа. Энэ бол цэвэр эрэлт нийлүүлэлтийн харьцаатай холбоотой. Одоо ипотекийн зээл олголтын эх үүсвэр нэмэгдсэн. Энэ сүүлийн байдлаар бол 1 их наяд төгрөгийн ийм ипотекийн зээл олгогдоод явж байгаа. Үүнийг харин давуу тал нь бол хөдөө орон нутагт олгогдож байгаа зээл авагчийн хувь өссөн байна лээ. 40 гаруй хувьдаа хүрчихсэн байна. Энэ бол өмнөхөөсөө илүү байгаа.

Одоо бид энэ олгож байгаа зээл рүүгээ чиглэсэн нийлүүлэлт буюу орон сууцыг барих асуудлууд гарч ирээд байгаа.

**Р.Сэддорж:** Хариулт нэмэх үү. 9 номер нэмье.

**Ц.Баярбат:** Тийм учраас Засгийн газраас энэ 4 жилийн хугацаанд 150 мянган орон сууцыг барьж, орон нутагт иргэдийг оршин суух орчин нөхцөлийг

сайжруулах ийм зорилт тавьсан байгаа. 25 оны энэ тэргүүлэгч бодлогын чиглэл дотор Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум, Улаанбаатар хотод анх удаа орон сууц авч байгаа иргэддээ бол 3 хувийн ипотекийн зээлийг олгоно.

Мөн түүнээс гадна олон айлын болон нэг айлын орон сууцуудын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ийм зорилтуудыг тавиад энэ чиглэсэн төлөвлөлтүүдийг яг яам хийгээд ажиллаж байна. Энэ бол олон талын оролцоотой. Энэ дээр илүү бид нар төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар явна. Барилгын салбар бол илүү либералчлагдсан салбар учраас хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт чухал байгаа. Энд нэг дутагдаж байгаа зүйл бол ялангуяа энэ орон нутагт барихад, Улаанбаатар ч ялгаагүй болчихлоо. Дулаан хангамжийн эх үүсвэр байхгүй болсон.

Ийм учраас энэ чиглэлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж байж, эсвэл тархмал эх үүсвэрүүдийг бид нар бий болгож байж үүнийг барих ёстой болж байгаа. Тэгэхээр энэ ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Тодруулга Бадамсүрэн гишүүн.

**М.Бадамсүрэн:** Орон сууцын үнэ өндөр байгаа нь эрэлт нийлүүлэлтийн харьцаанаас болж байгаа гэж үнэхээр хариуцлагатай яг хэлж байна. Чадаж байна уу тийм ээ. Үнэхээр үү, өөр шалтгаан нөхцөл байхгүй юу? Энэ шалтгаан нөхцөлийг та бүхэн тогтоох хэрэгтэй. Газрыг үнэлгээтэй авч байгаагаас болж байна уу, өндөр хүүтэй зээл авч байгаагаас болж байна уу, барилгын материалын үйлдвэрлэл дутмагаас болж байна уу, бонд, тээвэр логистикийн хүндрэлээс болж байна уу гэдгийг тогтоох ёстой. Ард түмэнд зөв мэдээлэл өгөх ёстой шүү. Ард түмэнд. Өнөөдөр хүний амьдралын хамгийн анхдагч хэрэгцээ бол орон сууц шүү дээ.

Ийм учраас энэ орон сууцад орёе, амьдаръя гэсэн багш нар зөндөө байна. Түмний хүүхдийг сургахад өөрийнхөө хүүхдүүдийг орхичоод, түлээ түли түлээд гал хөлийн аюул яах бол гээд ингээд сууж байгаа олон багш нар байгаа шүү дээ. Тэгэхээр энд ямар бодлого барих юм бэ. Энэ эрэл нийлүүлэлтээ зөвхөн шалтгаалаагүй 1 дүгээр шалтгаан гэдгийг бол танай яам ингэж үзэж байгаа бол энэ бол маш буруу шүү. Үүнийг би 1 дүгээрт нь тодруулж асууя.

2-т нь, энэ бодлогын зохицуулалт дээр яаж анхаарах вэ? Ялангуяа ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт 9 номер.

**Ц.Баярбат:** Түрүүнд ер нь бол бид нар энэ асуудлыг тодорхойлохдоо Монголбанк, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, холбогдох газруудтай бид нар бас уулзалтуудыг хийж байгаад, бид нар тэнд ямар үндсэн шалтгаан нөхцөлүүд нөлөөлж байгаа гэж байгааг авч үзэж байгаа. Хамгийн түрүүнд бол мэдээж нийлүүлэлт хамгийн чухал байгаа гэдгийг бол тодорхойлсон.

2 дугаарт, мэдээж баригдаж байгаа орон сууцууд дээр бас ченж хэлбэрийн ийм хар зах зээлийн зүйл бол бас бий. Иргэдэд эргэж хямд үнэтэй байхад нь аваад буцаад иргэдэд өндөр үнээр зардаг тийм тодорхой хэмжээний юунууд буруу зөрүү зүйлүүд гарч байгааг бид нар засах ёстой. Үүний үүднээс бол хуулийн болон эрх зүйн орчныг нэлээн сайжруулах чиглэлээр бид нар ажиллаж байна. Эндээ зориулаад энэ Орон сууцжуулалтын тухай хууль анхдагч хуулийн төслийг бид нар бас өргөн барьж, Улсын Их Хурлаар бас хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

Тэгэхээр бид нар бол ерөнхийдөө гарч байгаа юмыг бол яах вэ, амьдрал дээр гарч байгаа асуудлаар нь тодорхойлоод байгаа боловч энэ нь цаанаа өөрөө тогтолцоогоо их зөв

бүрдүүлж байж, урт хугацаанд зөв явах ёстой байдаг. Тэгэхээр энэ чиглэл рүүгээ бид нар гол нь бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ гэсэн ийм зорилттой. Энэ дээр бол зөвхөн яам ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Баярлалаа.  
Баатаржавын Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Сайн байцаана уу. Өдрийн мэнд. Өмнө нь бас олон гишүүд асуулт асуучихсан болохоор аль болохоор давхиулахгүйгээр 3 гол асуулт асууя гэж бодож байна.

БНХАУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар ийм ажил тусгагдсан байгаа. Тэгээд үүнийг тусгахдаа өмнө нь хийсэн Япон улстай хийсэн худалдааны хэлэлцээрийг хэр дүгнэж, тэндээс гарсан алдаа, оноог энэ улстай байгуулах хэлэлцээртээ тусгаж байгаа юу. Манай Монгол Улсад хэр ашигтай байж чадсан бэ гэдэг дээр нэг хариулт авъя.

Хоёрдугаарх нь болохоор дагуул хотуудыг хөгжүүлэх, бүсчилсэн байдлаар орон нутгийг хөгжүүлэх гээд нэлээн удаан бүгдээрээ ярьцаалаа. Төлөвлөгөөнд ч гэсэн орсон байна. Тэгэхээр энэ дээр хамгийн гол нь бүтээн байгуулалт хийхийн зэрэгцээ бизнес эрхлэгчид, хувийн хувиараа бизнес эрхлэгчид, хувийн хэвшлийнхэн очиж өөрсдийн сэдлээр тийм ээ, очиж амьдрах, өөрсдийн бизнес, үйл ажиллагааг явуулах тэр сэдэл бий болох тал дээр нь анхаарсан ажлууд төлөвлөгдсөн үү? Төрийн төсвийн мөнгөөр баахан бүтээн байгуулалт хийчихдэг. Эргээд тэр нь оновчгүй хий одоо нөгөө сүнс хот гэдэг шиг тийм бас байдлууд үүсэх вий.

Дараагийн нэг асуулт бол ногоон хөгжлийн үзэл санааг нэвтрүүлнэ гээд байгаа шүү дээ тийм ээ, ногоон эдийн засаг гээд бас нэлээн олон жил ярьсан. Тэгээд түүн дээр 14 том мега төсөл

эхнийх нь 5 гол төсөл нь энэ ондоо, ирэх ондоо хөрөнгө оруулалт хийгдэж эхэлнэ гэж байгаа. Бусад бас төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтууд бүтээн байгуулалтууд хийгдэнэ. Түүн дээр яг энэ хий ялгарал багт багатай, технологийн өндөр түвшинд хөгжсөн сэргээгдэх эрчим хүчийг ашигласан тийм барилга байгууламж, бүтээн байгуулалтууд хийгдэх нь яг төлөвлөгдөж чадсан уу, эсвэл эргээд нөгөө нүүрс бусад асуудлууд хэвээр үлдэх бол ногоон эдийн засаг, ногоон хөгжлийг нэвтрүүлнэ гэж хэлсэн хэвээр байж чадах уу гэдэг асуулт байна.

Бас нэг зүгээр энэ нэг техникийн алдаа гарчихсан уу. Хавсралт 3 дээр Хүний хөгжлийн индексийг 2022 онд 96 байсныг ирэх онд 95 болгоно гээд биччихсэн байгаа байхгүй юу. Нэг буурч байгаа юм шиг харагдаад байх юм. Энэ дээр магадгүй нэг тайпинг мистек гарчихсан байж магадгүй гэж бодсон.

Тэгээд зүгээр тодруулаад нэг асуухад Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк манай ирэх оны эдийн засгийн өсөлтийг 6-6,5-тай гарах байх гэж төсөл төлөвлөж байна. Манайх бол 8 хувь гэж хэлж байна.

Нөгөө талдаа инфляцын түвшинд би бас санаа зовж байгаа. 5+ -2 гээд сая Эдийн засгийн хөгжлийн яамны сайд 6,5 гэж хэлж байна. Түүн дээр яг 8 хувь, инфляц дээр 6,5 гэж хэлж байна. Энэ яг бодит байдалд биеллээ олж чадах уу гэдгийг л асуумаар байна. Ингээд дуусгая. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер Батхүү дарга.

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү Мөнхсоёл гишүүний асуултад хариулья.

1 дүгээрт нь, БНХАУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг айлын талд албан ёсоор хүсэлтээ тавьчихсан байгаа. Албан ёсоор бичгээр

хариу санал аваагүй байгаа. Зүгээр ажлын шугамаар холбогдоод ажиллахад бол иж бүрэн хэмжээнд байгуулах боломжтой гэдэг саналаа нөгөө талаас илэрхийлж байгаа. Таны асуусантай холбоотой Япон улстай байгуулсан 2015 онд байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрээр гарсан үр дүн нь яг одоогийн байдлаар бол тийм хангалттай биш байгаа. Японы талаас оруулж ирж байгаа импорт, Монголоос гаргаж байгаа экспортын зөрөө их өндөр байгаа. Манай талдаа алдагдалтай байгаа. Энэ дээр гарч байгаа дүгнэлт нь, гол дүгнэлт нь бол энэ эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг зөв зохистой ашиглах хэмжээнд засаглал тогтолцооны механизмууд нь ажиллаагүй байна. 2 талаас тохиролцсон барааны жагсаалт нь бас Монгол Улсаас экспортлох боломжтой тодорхой бараа бүтээгдэхүүнд хангалттай тусгагдаагүй байна.

3 дугаарт нь, бас хөрөнгө оруулалт ерөөсөө энэ хэлэлцээг дагаж олигтой орж ирээгүй байна гэсэн ерөнхий юу асуудлууд байгаа. Олон деталь асуудлууд бас байгаа. Энэ алдаа дутагдал, сургамж дээр үндэслээд бид нар БНСУ-тай хэлэлцээ хийж байгаа. Бас Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хувьд бол энэ асуудлыг засахаар ажиллаж байгаа. 1 дүгээрт нь бол энэ шинэ хэлэлцээр нь бол 14 бүлэг. Тэгээд дотроо бол эдийн засгийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, барааны үйлчилгээний гарал үүсэл гээд бүлэг бүрээр энэ асуудал нарийвчлан ярилцаж байгаа. Монгол Улсаас экспортлох боломжтой бүтээгдэхүүнийг аль болох илүү түлхүү татварын хөнгөлөлт хурдан хугацаанд эдлүүлэхээр хэлэлцээний модалитиг нь бол тэгж тохиролцсон байгаа.

Дээр нь бас нөгөө харилцан татвар чөлөөлөлтийн түвшин 90-ээс дээш хувиар буюу нэлээн их бололцоог бий болгохоор ажиллаж байгаа. Энэ төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой

засаглалын асуудлыг бас бид нар цоо шинэ байдлаар хийж байгаа. Бүлэг бүрээр дэд хороо байгуулах асуудлыг нь энэ удаа болиод, харилцан орчин үеийн шинэ дэвшилийг ашиглаад, платформ маягаар, хамтарсан платформ маягаар хөрөнгө оруулж, худалдаа эрхлэгчдийн асуудлыг шуурхай шийдэх байдлаар тогтолцооны саналыг тавиад нөгөө тал нааштай дэмжээд ажиллаж байгаа.

Дээр нь Евроазийн эдийн засгийн холбоотой бас Чөлөөт худалдааны хэлэлцээр түр хэлэлцээр хийж байгаа. Энэ онд багтаад яг ерөнхий асуудлуудаа тохиролцчихно. 375 бүлгийн барааг энэ 5 гишүүн 5 улс руу экспорт, айлын талаас импортын татваргүй квотгүйгээр нээлттэй гаргах тийм бололцоо бүрдэх юм. Энэ хэлэлцээний ач холбогдлын дагуу ХАА-н бүтээгдэхүүнүүдийн үнэ цэн нэмэгдэх, дайвар бүтээгдэхүүнүүд бас боловсруулалт үнэ цэн нэмэгдэх ийм олон талын ач холбогдолтой хэлэлцээ боломж хүлээлттэй байгаа.

Таны сая асуусан инфляцтай холбоотой асуудал дээр бас энэ оны яг одоогийн байдлаар 8 сарын байдлаар инфляцын гүйцэтгэл 6,5 хувьтай байна. Энэ оны төгсгөл рүү нэг 7,8 хувь гэж үзэж байгаа. Ер нь бол инфляц 7,5 хувь гэж үзэж байгаа. Энэ бол нөгөө Монголбанкны депозон дотроо зорилтот түвшин ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Нэмж хариулах уу? 3 номер.

**Ц.Батхүү:** Ирэх онд бид нар инфляцын түвшнийг 6,5 гэж, ирэх онуудад тэгж зорилтоо тавьж байгаа. Засгийн газрын төлөвлөлт нь бол Монголбанк бусад байгууллагаас ялгаатай нь бол таамаглал биш зорилтот түвшин гэж үзэж байгаа. Бид нар. Энэ зорилтоо хангахын төлөө Засгийн газрын бодлого, бодлогын тэргүүлэх чиглэл, төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөж ажиллаж байгаа. Инфляцыг өмнө нь төлөвлөж

байснаа жоохон өсгөсөн байгаа 1,5 нэгж хувиар. Өмнө нь бол 5 хувь гэж тооцож байсан. Энэ шалтгаан нь бол салбаруудад реформын шинж хийхтэй холбоотой. Жишээлбэл эрчим хүчний салбарт тарифын шинэчлэл хийхтэй холбоотой бас нөлөөлөл нь 1, 2 жил дамжаад тусгахдаа үүнийг бас давхар тооцсон байгаа.

Эдийн засгийн өсөлтийн хувьд бол бид нар ирэх онд 8 хувь гэж тооцож байгаа. Энэ гол шалтгаан нь бол Засгийн газрын урт хугацааны тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэх гэж зарлаж байгаа 14 мега төслийн хамгийн эхэнд байгаа төмөр замын холболтууд, ялангуяа экспортын гарцыг нэмэгдүүлэх чиглэлийн хөрөнгө оруулалтууд, бусад салбаруудын шинэчлэлийн арга хэмжээнүүдээ бид нар давхар тооцоололдоо тусгасан ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Тодруулга авах уу? Мөнхсоёл гишүүн. Мөнхсоёл гишүүний микрофон өгье.

**Б.Мөнхсоёл:** Уг нь өөр 2 асуулт байсан. Тэр нэг хавсралт дээр тоо буруу тавьчихсан байна уу тийм ээ. Тэгээд нөгөө 2 асуултын хариу. Окэй гэж байгаа юм байна тийм ээ. Дуусгая даа. Тэгэхдээ нөгөө протоколд асуултаа нөгөө 2 асуултаа бол бас давхар үлдээчихье. Дагуул хотод ногоон эдийн засаг юуг нэвтрүүлнэ гэдэгтэй холбоотойгоор.

**Р.Сэддорж:** Гантөмөр сайд 3 номер хариулах юм уу. Хариулъя 3 номер.

**И.Батхүү:** Хүний хөгжлийн индекс дээр бол нөгөө үзүүлэлт нь багасах тусмаа сайжирдаг. Бид нар бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр 10 нэгжээр урагшилуулъя гэсэн зорилт тавьсан байгаа. Энэ 25 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр бол нэг функтээр сайжруулах буюу 1-ээр бууруулна гэсэн зорилт тавьсан.



Ногоон хөгжлийн асуудлыг бол бид нар таны асуусантай холбогдуулаад хэлэхэд ер нь цаашидаа баригдах улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд дээр эрчим хүчний хэмнэлттэй, ногоон чиглэлтэй байх тийм шаардлагуудыг ажлын даалгаварт нь тусгах, ТЭЗҮ зураг төсөвт нь тусгах талаар чиглэл өгөөд ажиллаж байгаа. Ялангуяа шинээр байгуулагдах энэ Шинэ Зуунмод хот, Хөшигийн хөндийн төлөвлөлт бол тэр чигээрээ смарт ногоон хот байх чиглэлээр бас бид нар бодлогын чиглэлийг гаргаад ажиллаж байгаа.

Засгийн газраас бас ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр бодлогын нэг хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа. Жишээ нь пассив хаус гэдэг ч юм уу, эрчим хүчний хэмнэлттэй байгууллагуудыг төр, хувийн хэвшлийн түншлэл, санхүүгийн салбарынхантай хамтраад дэмжиж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. Томоохон төслүүд бол угаасаа санхүүгийн дизайн бүтцийг нь гаргахдаа бас ногоон элементүүдийг оруулаад хөрөнгө оруулалт ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Болчихлоо. Тийм, ногоон эдийн засаг, ногоон хот гэдэг чинь тэгээд л эрчим хүчнийхээ юутай хана мөргөөд байгаа юм биш үү. Эрчим хүчний тарифтайгаа. Ногоон хот ингээд явж байсан чинь гэнэт ингээд үүл бүрхэхээр төвийн эрчим хүчний систем рүүгээ холбогдож чадахгүй болчихоод байгаа юм биш үү. 3 номерыг нэг дахиад хариулчих.

**И.Батхүү:** Энэ ногоон хөгжил, ногоон санхүүжилт, энэ ногоонтой холбоотой асуудлууд ер нь хэд хэдэн талаас нь харах боломжтой байгаа. Таны хөндсөн асуудал бол, даргын хөндсөн асуудал бол хөрөнгө оруулалт талаасаа өнгөрсөн хугацаанд Монгол Улсад хийгдсэн сэргээгдэх эрчим хүчний төслүүд, түүн дээр үүсээд байгаа бэрхшээлүүдийн асуудал байгаад байгаа юм. Энэ бол бас зайлиггүй шийдэх ёстой хөрөнгө оруулалтын цаашидын орчныг

сайжруулах, гаднын хөрөнгө оруулалт, дохио болох талаасаа зайлиггүй шийдвэрлэх ёстой асуудлууд байгаа.

Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс бол яг энэ хөрөнгө оруулагчийн гомдлын асуудал Засгийн газрын хуралдаанаар оруулаад танилцуулаад тодорхой хэмжээнд шийдээд явж байгаа. Ер нь хөрөнгө оруулалтыг эрчим хүчний салбарт, цаашидаа хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахын тулд тарифын шинэчлэлтийг зайлиггүй хийх шаардлагатай гэж үзээд манай яамнаас энэ асуудлыг бас бодлогын шинэчлэлийн хүрээнд гаргаж ирж ярьж байгаа.

Энэ тарифын өсөлт нь өөрөө эрүүл зардлаа нөхөх хэмжээнд хүрчих юм бол эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт бол нэмэгдэх, заавал төсвийн ачаалал авахгүйгээр эрчим хүчний тодорхой чиглэлийн дэд бүтцүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Баярлалаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

**Л.Соронзонболд:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Нэг 5 асуулт байна.

1 дүгээрт, орон нутагт бизнес эрхэлж байгаа иргэдийн хувьд бол иргэд, ААН-ийн хувьд ялангуяа энэ бизнест ашиглагдаж байгаа бараа материалын дэлгэрэнгүй статистик мэдээлэл нэлээн чухал хэрэгтэй байна гэж яригдаж байгаа юм. Жишээ болгоод хэлэхэд жишээлбэл Дорнод аймагт газар тариалан, хүнсний ногоо тариалдаг иргэдийн хувьд бол аймгийн хэмжээнд хэдий хэмжээний төмс, лууван юу гэдэг юм нарийн ногоо гээд тийм ээ, дэлгэрэнгүй мэдээллээрээ байдаг бол тухайн хүмүүс жишээлбэл ногоо, хүнсний ногоо тариалахдаа тэдгээр мэдээллийг ашиглаж бас тариалалтаа хийх юм. Тэгээд тэр нь бас нөгөө тэр

улсуудын яг амьдралд нь бас бас бодитой хэрэг болох юм гэж ярьж байна л даа.

Тэгэхээр энэ тал дээр ер нь ХХААХҮЯ болон ҮСХ дээр ер нь 2025 онд энэ чиглэлээр ямархуу ажил хийхээр төлөвлөж байна вэ гэж 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт нь болохоор бол энэ алслагдсан сум, орон нутагт бизнес эрхэлж байгаа болон амьдарч байгаа иргэдэд ялангуяа энэ боомтын сэргэлтийн бодлого бол их нөлөөтэй, үр ашигтай байгаад байгаа юм. Гэхдээ болохоор бол тухайн цаад улсын бодлогоос хамаардаг юм уу, зарим төрлийн бараа бүтээгдэхүүнийг боомтоор оруулах хязгаарлалт байдаг юм байна. Жишээ болоход бол Дорнод аймгийн Халхгол сумын Баянхошуу болон Сүмбэр боомтоор барилгын материал оруулж болдоггүй юм байна.

Тэгэхээр 2025 онд ер нь энэ боомтын сэргэлтийн хүрээнд энэ талаар БНХАУ-тай энэ барилгын материалыг эдгээр боомтоор оруулах талаар ер нь яриа хэлэлцээ хийх төлөвлөгөө байна уу гэж 2 дугаар асуулт байна.

3 дугаарт болохоор бол энэ зүүн бүсэд өнгөрсөн жил бол зуд болж нэлээн олон хүмүүс бол малгүй болсон. Ялангуяа малгүй болсон залуучууд хот, аймгийн төвд бол ажил хийж байна. Гэхдээ болохоор энэ ажлын хөлсөө авч чадахгүй хохирох асуудал бол их гардаг юм байна. Ялангуяа барилгын төсөл дээр ажилласан хүмүүс бол ажлын хөлсөө авч чаддаггүй. Тэгээд шүүхээр хуулиар яваарай гээд нөгөө хэд нь хэлчихдэг. Нөгөө залуучууд бол бас тэр талын мэдлэг багатай учраас хохироод үлддэг ийм асуудал байгаад байгаа.

Тэгэхээр энэ тал дээр ялангуяа энэ цагийн хөдөлмөр эрхэлж байгаа, богино хугацаатай ажил хийж байгаа хүмүүсийн энэ хөдөлмөрийн харилцааг хамгаалах тал дээр ер нь манай улс

дараа 2025 онд ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ гэж энэ асуулт байна.

4 дүгээрт нь болохоор орон нутагт энэ бэлчээртэй холбоотой маргаан их гарч байна. Ялангуяа их олон малтай хүмүүс өөр сумын нутагт орж ирдэг. Малын хөлийн татвар тухайн хүнээс авъя гэхээр би өөрийнхөө уугуул сумдаа татвараа төлдөг өө гээд ингээд тухайн оронд татвар төлдөггүй ийм асуудал үүсээд байдаг. Энэ талаар ер нь 2025 онд бид ер нь ямар бодлого барьж ажиллах юм бэ гэж асуулт байна.

Дараагаар нь болохоор бол энэ хашиандаа сайхан амьд амьдаръя гээд төсөл хөтөлбөрийг бид нар хэрэгжүүлнэ гэж ярьж байгаа. Энэ дээр болохоор хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт эрчим хүчний хэмнэлттэй ийм бие даасан шийдэлтэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг өгнө гэж бол туссан байсан. Тэгэхээр 2025 онд энэ хэрэгжих үү гэж нэг асуулт байгаад байна.

Дараагийн асуулт маань болохоор бол энэ сумдын сургууль, ялангуяа дунд ангиас дээш бол хүүхдийн тоо бол маш цөөхөн байгаа. Тэр нь юутай холбоотой байна вэ гэхээр математик, физик, хими, биологийн багш нар байхгүй. Хүүхдийнхээ боловсролоос болоод эцэг эх нь бол хүүхдээ өөр тийм багштай сум руу нүүлгэж шилжүүлж байна. Эсвэл аймгийн төв рүү шилжүүлж байна. Тэгэхээр энэ тал дээр 2025 онд ямар ахиц дэвшил гарах вэ гэж асуултыг бол Боловсролын яамнаас асуумаар байна.

Эдийн засгийн хөгжлийн яам 3 номер. 3 номер.

Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн хөгжлийн яам Төрийн нарийн бичгийн дарга Батхүү.

Таны асуусан 1 дүгээр асуулттай холбоотой орон нутгийн ААН ер нь орон нутагт хийгдэж байгаа бизнес, түүний гарч байгаа ДНБ-ийг бол ҮСХ тооцож нэгтгэгдэж явдаг. ҮСХ бол бас энэ боловсруулж байгаа, гаргаж байгаа статистикийн мэдээллийг олон нийтээр нээлттэй байлгах талаар бас нэлээн сайн ажиллаж байгаа.

Гагцхүү яг орон нутгийн бизнес эрхлэгчид энэ мэдээллийг хүргэх талаас нь бас нэмэлтээр бас ажлууд хийх нь зүйтэй юм шиг санагдаж байна.

2 дугаарт нь орон нутагт бизнес эрхэлж байгаа ААН-үүд хилийн боомтоор импортоор тодорхой бараа, бүтээгдэхүүн материал оруулахтай холбоотой асуудал бол 2 улсын хоорондын хилийн боомтоор нэвтрүүлэх бараатай холбоотой протокол горимууд байдаг. Энэ дээр бас ГХЯ, гаалийн байгууллагууд бас цаашидаа хамтраад анхаарал тавиад ажиллах бүрэн боломжтой. Яг одоогийн байдлаар бол экспортын ХАА-н бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүнийг экспортын чиглэлээр бүх боомтоор гаргах чиглэлээр яриа хэлцэл хийх даалгавар Засгийн газраас өгөгдөөд байгаа. Энэ талаар ажиллаж байгаа.

Бусад асуултуудыг холбогдох яамнууд хариулчих нь зөв байх. 30 сая төгрөгийн асуудал бас 25 оны төсөв дээр ч гэсэн суугдаад явж байгаа.

**Р.Сэддорж:** ХААЯ хэдэн номерт байна. 9 номер Жамбалцэрэн дарга.

Соронзонболд гишүүний асуултад хариулъя. ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулаад 25 оны жилийн төлөвлөгөөний саналуудад тусгагдсан салбарын бодлогын хүрээнд ер нь цэвэр хувийн хэвшилээ дэмжинэ. Энэ хүрээндээ салбарын экспортын орлогыг нэг 2-3

дахин нэмэгдүүлбэ. Суурь түвшин бол нэг тэрбум ам.долларын экспорт ХАА-н салбараас явж байгаа. Үүнийг бол 2-3 тэрбум ам.долларт хүргэе.

Импортын хамаарлыг нэг 4 жилийн хугацаандаа 30 хувь бууруулах ийм бодлого зорилттой ажиллаж байгаа. Салбарын хэмжээнд салбарын бизнесийн байгууллагууд ялангуяа МАА, газар тариалан, хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл гээд эдгээр салбаруудын тоон мэдээллүүд бол гарчихсан байгаа. Статистик дээр ч гэсэн энэ үзүүлэлтүүд гарч байгаа.

Аймаг, орон нутгуудад бол тухайн шатын Засаг даргын ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя 9 номер.

**Т.Жамбалцэрэн:** Хүнсний тухай хуулиараа тухайн шатын орон нутгийн нэгжийн тухай хуулиараа ч гэсэн бүх шатны Засаг дарга нарын эрхлэх асуудлын хүрээнд эдгээр асуудлууд бүрэн тусгагдсан байдаг. Орон нутгийн өөрөө удирдах байгууллага бас энэ чиглэлийн мэдээллээр хангаад явах бололцоотой. ХХААХҮЯ-ны хувьд бол ирэх 4 жилийн зорилтын хүрээнд нэг 4 том хөтөлбөрөө хэрэгжүүлнэ гэж ингэж үзэж байгаа.

1 дүгээрт, нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал, хүнсний хангамж, аюулгүй байдлын үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, мөн малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэнийг өсөн нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэрлэлийн түвшнийг ахиулах зорилготой “Цагаан алт” хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын даргын санаачилсан “Шинэ хоршоо чинээлэг малчин” энэ хөтөлбөр Атрын 4 дүгээр аянуудыг хэрэгжүүлнэ. Энэ хөтөлбөрүүдэд цэвэр хувийн хэвшлийн санаачилга дээр тулгуурлаад арилжааны банкны эх үүсвэрээр нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй хөрөнгө оруулалтын болон

эргэлтийн хөрөнгийн зээлүүдийг олгох, улсын төсвөөс тодорхой хүүгийн хөнгөлөлтүүдийг нь олгох хууль эрх ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Гэр бүл, нийгмийн хамгааллын яам цалин хөлстэй холбоотой асуудал. 9 номерын микрофон өгье.

Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга Хишигбаяр гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.8-д бол зайнаас цагаар, цахимаар ажиллах эрх зүйн орчныг сайжруулах зорилт бол туссан байгаа. Энэ хүрээнд бол манай яамны зүгээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд шинэчилсэн найруулга хийхээр өнөөдөр ажиллаж байгаа. Энэ хуулийнхаа төслийг бол бид нар Засгийн газрын 100 хоногийн ажил болон Улсын Их Хурлын намрын чуулганд багтаж өргөн барихаар ажлын хэсэг гараад өнөөдөр ажиллаад явж байгаа. Тэгэхээр энэ хуулийн төсөл дээрээ бид нар илүү нарийвчилж ажиллаад, эрх зүйн орчныг нь нээж ажиллана гэж зорьж байгаа.

**Р.Сэддорж:** Боловсролын яам хариулъя. Орон нутгийн сургуулийн хүртээмжийн талаар. Хүн байна уу? Боловсролын яамнаас. Байхгүй байна. Тодруулга авах уу?

Соронзонболд гишүүн.

**Л.Соронзонболд:** Би нөгөө бэлчээрийн асуудал дээр татвар, нөгөө үндсэн харьяалалтай сумдаа татвар төлсөн гээд байдаг. Гэтэл өөр одоо газар өвөлжөөд, хаваржаад байдаг тийм ээ. Энэ дээр дараа жил ямар бодлого барьж байна вэ гэж асуусан шүү дээ.

**Р.Сэддорж:** Хүнс, хөдөө аж ахуй. Ганбат дарга 7 номер.

**Ж.Ганбат:** Би энэ 2 асуултад нь хариулъя. Эхнийх нь бол тэр малын

хөлийн татвар гээд. Малын хөлийн татвар бол нөгөө орон нутаг өөрсдөө бие дааж тогтоож байгаа. Тэгэхээр бол яах вэ уг нь бол зарчим бол татвар төлсөн газраа тэр мал нь бол байх ёстой. Өөрөөр хэлэх юм бол яг энэ дээр нэг 2 асуудал дээр ийм асуудал үүсээд байна. Нэг нь мал дээр, нөгөөдөх нь авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл дээр.

Тэгэхээр яах вэ, бид бол Сангийн яамнаас орон нутгийн төсвийг хянахдаа бол орон нутагт өгч байгаа чиглэл нь бол тэр тухайн эд хөрөнгө, автомашин байдаг юм уу, мал бол байгаа газраа татвараа төлөх ёстой. Жишээ нь зүүн бүсэд байгаа мал бол тэндээ татвараа төлөх ёстой гэдэг энэ асуудлыг ингээд зохицуулах, тэр эсвэл 2 сум хоорондоо, аймаг хооронд бол энэ асуудлыг зохицуулах гэдэг байдлаар асуудалдаа ханд гэдэг ийм чиглэлийг бол орон нутагт бол өгч байгаа.

2-т таны асуусан тэр нөгөө зуд болсонтой холбоотой яах вэ, Засгийн газраас гол баримталж байгаа бодлого бол саяын энэ өнгөрсөн өвлийн зудтай холбогдуулан энэ гамшигийн даатгалын асуудлыг ер нь бүх талын оролцогч талуудыг оролцуулаад энэ гамшигийн даатгал буюу малын энэ ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцэж хариулъя 7 номер.

**Ж.Ганбат:** Малын индексжүүлсэн даатгалын хуулийг өөрчлөхөөр ингээд ажиллаж байгаа. Энэ дээр гол зорилго нь хүртээмжийг нэмэгдүүлэх гэдэг байдлаар ингэж ажиллаж байгаа. Энэ дээр нийтдээ би нэг статистик тоо хэлэхэд бол өнгөрсөн зудын хохиролд үндэсний давхар даатгалын сангаас 2024 онд 22 мянган малчин өрхөд 16,8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгохоор болоод үүнийг бол эхнээсээ олгоод эхэлчихсэн байгаа. Энэ дээр хамгийн их нь буюу хамгийн их нь бол Сүхбаатар аймаг хамгийн их хохирол



амссан гэдэг ийм мэдээллээр ингэж байгаа. Тэгээд энэ мөнгө нь бол эхнээсээ энэ олгогдоод бол даатгалаас үндэсний давхар даатгалаас олгогдоод явж байгаа юм байна.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Дашицэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Д.Энхтүвшин:** Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Ер нь сүүлийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр ч, тэгээд энэ оруулж ирж байгаа хөгжлийн төлөвлөгөө эд нараа харахаар нэг хувийн хэвшлийг дэмжинэ, төрийн оролцоог бууруулна гэсэн нэлээн гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжинэ, эдийн засгаа солонгоруулна, бизнес эрхлэгчдээ дэмжинэ гэсэн иймэрхүү заалтууд оршил хэсэгт нь байгаа мөртөө яг ингээд хийх юмыг нь харахаар ерөөсөө тийм хангалттай юм байхгүй байгаа харагдаад байна.

Тэгээд энэ 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг харахаар бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ гэхээр энд оруулсан жишээлбэл заалтууд бол ямар ч хангалтгүй байна. Ер нь бол ААН-үүдийн хувьд ялангуяа жижиг дунд ААН-үүдийн хувьд бол хөгжих битгий хэл яг яаж оршин тогтнох вэ гэдэг асуудлууд нэлээн тулж байна. Тэгэхээр энэтэй холбоотой зүгээр нэг тодруулах юм нь гэхээр яг энэ төлөвлөгөөг боловсруулахдаа энэ оролцогч талуудаа яаж сонсдог юм бэ? Тэгээд жишээлбэл төр нь, жишээлбэл нэг тал нь өөрөө сонсоод энэ төлөвлөгөөнүүдээ гаргачихдаг юм уу? Зүгээр яг хувийн хэвшлийн өнцгөөс харвал энэ бол хангалтгүй төлөвлөгөө харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ эдийн засгийн одоо жишээлбэл ДНБ-ий гол ачааг үүрч байгаа хувийн хэвшил, ялангуяа жижиг дунд ААН-үүд, жижиг дунд ААН-үүдийн хувьд бол ажлын байрны жишээлбэл тоо харвал татварын бол бараг 60 орчим хувийг төлж байна. Ажлын байрны 90 орчим хувийг бий болгож энэ том салбар луу

бол ерөөсөө жишээлбэл нэг их хангалттай арга хэмжээнүүд авахгүй байна. Тэгэхдээ яах вэ, яг тоогоороо харвал ДНБ-д эзэлж байгаа хувь нь 5,5 ч юм уу бага байгаа боловч яг ингээд нийгэмд үзүүлэх нөлөөллийн хувьд асар өндөр ийм аж ахуй хэсэг байгаа. Тэгээд энэтэй холбоотой дорвитой арга хэмжээнүүд хийгдээгүй харагдаад байна.

Тэгэхээр энэ санал асуулга юмаа яаж авдаг вэ? Энэ талаар зүгээр бас тодруулга авмаар байна. Үүнийг жишээлбэл боловсруулахдаа бизнес эрхлэгчдийнхээ саналыг яаж сонссон юм бэ?

Өөр нэг юм гэхээр жишээлбэл бизнес эрхлэгчдийн хувьд бол татвар, нийгмийн даатгалтай холбоотой асуудал, дээр нь энэ ажиллах хүчинтэй холбоотой асуудал, зээл инфляцтай холбоотой асуудлууд чухал байгаа. Жишээлбэл 2019 онд ковидын өмнө нийгмийн даатгалын байсан өр энэ оны 6 сарын байдлаар гэхэд 3,6 дахин нийгмийн даатгалын өр ААН-үүдээс төлөх өр ингээд нэмэгдсэн. Ийм тоо байна л даа. Тэгэхээр энэ тоо жишээлбэл бодитой ийм тоо байна уу? Өнөөдөр харсан тоогоор болохоор 540 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын авлага байна, ААН-үүд төлж чадахгүй байна гэсэн үг. Тэгэхээр энэ тоо болохоор 19 онд 150 тэрбум байж байгаад 3,6 дахин нэмэгдсэн ийм байдалтай байна. Тэгэхээр энэ дээр та хэд яаж харж байгаа вэ. Нийгмийн даатгалын энэ өр ингээд төлөгдөхгүй яваад байх уу. Энэ дээр жишээлбэл яаж ямар дүгнэлт хийж байгаа гэдгийг асуумаар байна.

Дээр нь хүний нөөцтэй холбоотой ажиллах хүчний болон хомсдолтой том жижиг гэхгүй бүгд асуудалтай байгаа. Тэгээд энэ дээр уул нь удаа дараа хүсэлт тавьж байгаа ажиллах хүчний энэ гаднаас ажилтан оруулж ирэх энэ асуудал дээр ялангуяа улирлын шинжтэй барилга байна, аялал жуулчлал байна, ХАА байна гэх мэтчилний улирлын

шинжтэй, дээр нь энэ бага үнэлгээтэй хөдөлмөрийн энэ ажлын байрууд дээр гаднаас ажилтан оруулж ирэх тал дээр хүсэлт тавиад ерөөсөө энэ татварын чөлөөлье, хасъя гэхээр ерөөсөө тодорхой хариулт хэлэхгүй байгаа. Тэгээд энэ дээр жишээлбэл ямар бодлого барьж байгаа вэ. Энэ дээр ямар нэгэн өөрчлөлт байх уу үгүй юү гэж асуумаар байна.

Дээр нь түрүүн Ганхуяг гишүүн бас асууж байна. Яг энэ Төрийн өмчит компаниудын жишээлбэл зарцуулж байгаа энэ шийдвэрүүдийн дүн асар өндөр байна. Жишээлбэл энэ төрийн өмчит Эрдэнэт дээр, Эрдэнэс тавантолгой дээр чинь хөрөнгө оруулалтын дүнгүүд бол их наяд хэмжээнд ийм хөрөнгө оруулалтын асуудлууд хоорондоо өр зээлд энэ асуудлуудыг бас ингээд шийдээд яваад байдаг юм байна. Түрүүн бас Гантөмөр сайд бас хэлэх шиг боллоо. Үүнийгээ бол Эдийн засгийн байнгын хороон дээрээ бас ингээд авч ярилцах бололцоотой гээд.

Тэгээд энэ ер нь Хөрөнгө оруулалтын шийдвэр ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт Эдийн засгийн хөгжлийн яам 3 номер.

Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Энэ Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа бас өнгөрсөн хавар өргөн барьсан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл дээр тусгагдсан арга хэмжээ, бодлогын чиглэлүүд бас нэлээн их хадгалагдсан, бодлогын тогтвортой байдал. Үүний гол нэг цөм нь бол бас хувийн хэвшлийг хамгаалах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, жижиг дунд бизнесийг дэмжих агуулууд нэлээн их орсон байгаа. Энэ бодлогын чиглэлүүдийг гаргахдаа өнгөрсөн хугацаанд Ерөнхий сайдын манлайллын доор хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, хөрөнгө оруулалт, бизнес эрхлэгчдийг сонсох,

өглөөний уулзалт гэх мэтчилэн олон арга хэмжээн дээр гаргаж байсан санал, дүгнэлт, зөвлөмжүүд, олон улсын байгууллагууд энэ бизнесийн чөмбөрүүдийн саналуудыг бас бид нар харгалзаж үзээд, энэ бодлогын төлөвлөлт хэлбэрт нь, хөгжлийн баримт бичгийн төлөвлөлт хэлбэрт нь оруулаад ингээд тусгасан байгаа. Энэ бодлогын баримт бичиг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө маань өөрөө зөвхөн улсын төсвөөр хэрэгжүүлэхгүй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлууд бас ингээд Засгийн газрын зүгээс анхаараад тэргүүлэх чиглэлүүдээ оруулаад явж байгаа. Энэ цаад агуулгаараа бол энэ хувийн хэвшлийн зорьж хийх гэж байгаа бизнесийг тэр агуулгаар нь төрөөс дэмжээд бодлогоороо ингээд дэмжиж байгаа гэсэн агуулгатай хөрөнгө оруулалтын хооронд нь уялдааг нь бас хангаж төлөвлөлтийг нь хийж байгаа.

Энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө маань өөрөө бас бусад яамнуудын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөндөө задраад тусгагдаад явна. Яам бүр энэ бодлогын арга хэмжээ, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ цаашидаа олон нийттэй нийгэмтэй хамтарч ажиллах, саналыг нь авах, төсөл, арга хэмжээг нарийвчилж хэрэгжүүлэх тал дээр бол анхаарч ажиллах бүрэн боломжтой байгаа.

Таны дурдсан жижиг дунд бизнесийг дэмжихтэй холбоотой ялангуяа урт хугацаатай, хүү багатай зээлийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, борлуулалтыг нь дотоодын мөн жижиг дунд үйлдвэрлэлийн борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжих, жижиг дунд бизнес эрхлэгчдийг бизнесийн корпорацын үйлчилгээг бойжуулан хөгжүүлэх гэх мэтчилэн нэлээн их асуудлууд энд бас туссан байгаа. Яг энэ сэдвээр нь бас тусад нь гаргаад танд хүргүүлье.

**Р.Сэддорж:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Нийгмийн даатгалтай холбоотой, гадаад ажилтантай холбоотой. 9 үү, хэд вэ? 9 номер.

**А.Хишигбаяр:** Гишүүний асуултад хариулъя. НДШ-ийн өр 2023 оны хагас жилийн байдлаар 540 тэрбум төгрөгт хүрсэн байгаа. Ковидын нөхцөл байдлын үед бол НДШ-ийг ААН байгууллага даатгуулагчдаас чөлөөлсөн. Нийтдээ 918 тэрбум төгрөг бол чөлөөлсөн. Ийм бас арга хэмжээг тухайн үед аваад бол хэрэгжүүлж байсан. Өнөөдөр нийгмийн даатгалын байгууллага бол шимтгэлийн өр авлагыг барагдуулахаар бол бас хэд хэдэн ажлыг зохион байгуулж байгаа. Өр авлагыг барагдуулах аяныг бас өнөөдөр зохион байгуулаад явж байна. Өнөөдөр 6 дүүрэг, 4 аймаг дээр энэ аян бол хэрэгжээд явж байна. Энэ хүрээнд бол ААН байгууллагад мэдэгдэл өгч байна. Мөн өрийг барагдуулах графикуудыг харилцан гэрээ байгуулж бас тохиролцоод бол явж байгаа.

Өнөөдрийн байдлаар хамгийн их өндөр өр авлагатай аймаг бол Сэлэнгэ аймаг байгаа. Энэ аймаг дээр өнөөдөр яг нийгмийн даатгалын байгууллага өнөөдөр ажиллаж байна.

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя 9 номер.

**А.Хишигбаяр:** Гадаадын энэ хөдөлмөр эрхлэлтийн асуудал дээр бол яг өнөөдөр надад бол мэдээлэл байхгүй байна. Би танд тусгайлан мэдээлэл бэлдээд бас явуулъя. Би нөгөө нийгмийн хамгааллын чиглэлийн асуудал хариуцдаг болохоор.

**Р.Сэддорж:** Эрдэнэс Монгол компани, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар. Аль нь вэ, 4 номер. Дараа нь төрийн өмч.

**С.Наранцогт:** Худалдан авалттай холбоотой бол бид нар төрийн өмчийн компаниуд хүнээс хамааралгүй хиймэл оюун ухаан дээр суурилсан ийм тогтолцоог нэвтрүүлж эхэлж байгаа юм. Эрдэнэтээс энэ зунаас Эрдэнэт үйлдвэр хэрэгжүүлээд эхэлсэн. Энэ оны эхний, ирэх оны эхний улиралд бол ер нь Эрдэнэс Монгол нэгдлийн компаниуд энэ платформ руу төрийн худалдан авах агентлагтай хамтарч хэрэгжүүлэх ийм төлөвлөгөө гаргаад ажиллаж байна. Ер нь гол нь яах вэ, энэ хууль эрх зүйн тодорхой сайжруулах асуудал байгаа ч гэсэн ер нь яах вэ, зүгээр ихэнхдээ энэ хүнээс хамааралтай асуудлууд байна гэсэн хардлага бас зарим тохиолдолд тийм юмнууд гараад байгаа учраас тэр ер нь ийм боломж бол байгаа юм байна. Хэрэгжээд бас үр дүн гарч байгаа учраас энэ чиглэл рүү ингээд төлөвлөгөө гаргаад ажиллаж байна.

**Р.Сэддорж:** Төрийн өмчийг хариулах уу. Төрийн өмчийн дарга 8 номер.

**Б.Цэнгэл:** Бид АТГ-тай бол бас хамтарч ажиллаж байгаа. Тэгэхээр ер нь бол бас зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл энэ тэр бол бас удаа дараа ирүүлж байсан. Тэгэхээр энэ чиглэлээр бид Эрдэнэс Монгол компаниагаа хамтраад ер нь бол худалдан авалтыг нээлттэй, ил тод болгох, шилэн болгох ажлыг бас эхлүүлээд явж байгаа. Одоо бол Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Монголын бол худалдан авалтууд ерөнхийдөө цахим хэлбэрээр нээлттэй ийм сонгон шалгаруулалтын зарчмаар явж байгааг та бүхэнд бол хэлье. Гэхдээ мэдээж бол цаашидаа анхаарах сайжруулах зүйлүүд бол байгаа. Энэ дээр бол санал нэг байна.

Ер нь бол та бүхэн мэдэж байгаа, Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс тавантолгой бол Монгол Улсын төсвийн орлогын зонхилох хувийг бүрдүүлж байгаагийн хувьд бол үйлдвэрлэлийг хэвийн ажиллагааг авч явах үүднээс бас зарим нэгэн тохиолдолд нэн шаардлагатай

худалдан авалтыг хийдэг ийм зүйлүүд байдаг. Гэхдээ үүнийг цаашидаа аль болохоор шилэн болгох, нээлттэй болгох гэдэг юмыг бас шаардлагууд тавигдаж байгаа учраас энэ чиглэл рүү нь шахаж ажиллаж байгаа. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Цэнгэл даргад баярлалаа. Тодруулга Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Төрийн өмч, би яах вэ нөгөө төрийн өмчтэй холбоотой энэ тэр дутуу таслагдчихсан, нөгөө хэлж чадаагүй асуух гэж байсан юм болохоор илүү нөгөө хөрөнгө оруулалттай холбоотой, том том жишээлбэл бүтээн байгуулалттай холбоотой, хөрөнгө оруулалтын төслүүд дээр бас жишээлбэл бид нар Улсын Их Хурал дээр бас нэлээн шүүлтүүрээр олон талаас нь ордог. Зүгээр яг төрийн өмчит компаниуд дээр бас яг энэ хэмжээнд байж чаддаг юм болов уу гэдэг бас зүгээр эргэлзээ байгаад байгаа юм. Тэр талаар л илүү асуусан юм. Тийм, зээлтэй холбоотой нөгөө түрүүн гэхдээ яах вэ, түрүүн Ганхуяг гишүүн дээр бас нөгөө хоорондоо зээл өгдөг асуудлуудыг асуучихсан байгаа. Тэгэхдээ яах вэ, илүү би бол хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэрүүд дээр яг хангалттай юу хянаж шалгаж чаддаг байгаа гэдэг талаар тодруулга авах гэсэн юм.

**Р.Сэддорж:** 4 номер Наранцогт дарга хариулъя.

**С.Наранцогт:** Энхтүвшин гишүүний асуултад тодруулж хариулъя. Яах вэ, өмнө нь бол ингээд ялангуяа манай нэгдлийн харьяанд том компаниуд дээр явж байсан том том төслүүдийн шийдвэр хэрхэн гарсан бэ гэдэг дээр бас нэлээдгүй тийм асуудал яригддаг. Гэхдээ ер нь зүгээр энэ том шийдвэрүүд дандаа л Засгийн газар, Их Хурлын түвшинд ихэнхдээ гарч байсан юм байна лээ.

Тэгэхээр цаашидаа бол бид нар яах вэ гэхээр энэ бол эрх зүйн хувьд ч гэсэн

цэгцэрсэн. Үндэсний баялгийн сангийн хуулиар бол энэ Эрдэнэс Монгол нэгдлийн харьяаны хэрэгжих энэ төсөл, хөтөлбөрүүд бол зөвхөн энэ дунд, урт хугацааны стратеги төлөвлөлтөд орсон, орж батлагдсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гээд ингээд хуульчлаад өгсөн байгаа.

Мөн түүнчлэн энэ сая нүүрсний сонсголыг дагаад ч бас манайтай холбоотой Их Хурлын тогтоол шийдвэрүүд гарсан. Манай компаниуд тэгж 1 дүгээрт, үндсэн үйл ажиллагаатай холбоотой аливаа ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт үргэлжлүүлъя. 4 номер.

**С.Наранцогт:** Үндсэн үйл ажиллагаанаас гадуур янз бүрийн бас санхүүжилтүүд, зээл олгогддог асуудлууд байсан. Түрүүн бас Ганхуяг гишүүн ярьж байна лээ. Тэгэхээр энэ асуудлууд ингээд хууль, эрх зүйн хувьд хязгаарлагдаж байгаа. Цаашидаа бол энэ төсөл, хөтөлбөрийн хувьд бид стратеги төлөвлөгөөнд тусгагдаж байгаа төсөл, хөтөлбөрөө бол хувьцаа эзэмшигч буюу Засгийн газар дээр үүнийгээ танилцуулж, чиглэл авах ийм байдлаар зохицуулагдаад явж байгаа. Тэгэхээр өмнө нь яах вэ, нэг компанийн гүйцэтгэх удирдлага болоод ТУЗ-ийн түвшинд ингээд шийдвэрүүд, том том шийдвэрүүд гарсан гэж ингэж яригддаг. Бас энэ дээр бас тодорхой хардлагууд явдаг ийм асуудал байсан. Одоо бол энэ асуудлууд хязгаарлагдсан гэж ойлгож бол болно.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууя. Мандхай гишүүн.

**М.Мандхай:** Сайн байцгаана уу. Би нэг юм тодруулах гэсэн юм. Энэ ХХААХҮЯ-тай холбоотой асуулт гарч ирж байх шиг байна. Сая ээлжит бус чуулганаар Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3



дугаар зүйлийн 3.3 дахь заалт дээр нэмж санал оруулсан. Санал оруулаад ээлжит бус чуулганаар бол батлагдсан байгаа. Энэ нь болохоор 3.3.4.3 МАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хоршооны загвар төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх, сургалт зохион байгуулах гэсэн заалт бол орсон байгаа.

Тэгээд яг энэ хөтөлбөр дээр танай урсгал зардал дээр бол ямар ч тийм төсвийн урсгал зардлыг харахаар энэтэй холбоотой чадавхжуулах, сурах загвар хоршоо гаргах, бэлтгэх гэсэн утга агуулгатай үг бол огт нэгд алга байна.

2 дугаарт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд шалгуур үзүүлэлтийн хүрээнд бас мөн адилхан харахаар 30.8 дээр 30.8.1 болохоор зөвхөн хоршоодод шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ гээд оруулж өгсөн байгаад байгаа. Тэгээд ингээд яг ингээд төсвийг хүртэл харахад дандаа 500 тэрбум төгрөгийн зээл, санхүүжилт олгохтой холбоотой байгаа болов ч эдгээр 3.3.4.3 ерөөсөө заалтад тусаагүй байна. Тэгэхээр энэ заалт 1 дүгээрт, хаана тусаж байгаа вэ? Задаргааг нь хаанаас авч болох вэ гэдэг мэдээллийг авмаар байна.

2 дугаар асуулт болохоор 30.8 дээр хоршоодод шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ гээд 25 оныхоо зорилтот түвшин 26 мянган хоршоодын тоог оруулчихсан байгаад байгаа юм. Тэгээд энэ алдаа байсан уу, эсвэл хоршоо малчны тоо гэж бичих гэж байгаад хоршоодын тоо гээд биччихэв үү? Яагаад гэхээр одоогийн байдлаар 518 тэрбум төгрөг олгогдоод, 4018 хоршоод л зээл авсан байгаа. Одоо бол 25 оны төсөв дээр бол 500 тэрбум, сая бол 500 гээд батлагдсан. Гэхдээ энэ 26 мянга хүрэх хэмжээнд тэр хэмжээний зээл санхүүжилт бол олгогдох нь бол

худлаа байх. Тэгэхээр энэ дээр бас нэг тайлбар авъя гэж бодож байна.

**Р.Сэддорж:** Жамбалцэрэн дарга 9 номер. 9 номер.

**Т.Жамбалцэрэн:** Мандухай гишүүний асуултад хариулъя. Тэр сүүлийнхээс нь хариулчихъя. Тэр тоо бол техникийн алдаа байна. Энэ болохоор малчин өрхийн гишүүдийнх нь тоо байгаа юм.

ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулдаг. Хоршооны бодлогыг хоршооны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хурдасгуур төв манай Жижиг, дунд үйлдвэрийн газар, ХХААХҮЯ, ЗГХЭГ-ынхан энэ 24 оны эхний хагаст хамтран аж ажилласан.

Шинэ Засгийн газар бүрдсэнтэй холбоотой хурдасгуур төвөөс 12 хүний орон тоог Жижиг, дунд үйлдвэрийн газар дээр шилжүүлж, бүтэц орон тоог шинэчлэн зохион байгуулсан. Энэтэй холбоотой сайдын эрхлэх асуудлын хүрээнд олгож байгаа зээлийн хүүгийн хөнгөлөлтийг Жижиг, дунд үйлдвэрийн газар дээр шилжүүлээд тэгээд энэ оны 518 тэрбум, төсвийн тодотголоор батлагдсан 500 тэрбумтай энэ үндсэндээ 1 их наяд төгрөгийн зээлийг гаргана гэсэн ийм тооцоололтой, хүүгийн хөнгөлөлт нь бол сайдын багцад суучихсан байгаа. Ирэх онд дахиад 500 тэрбумын төсвийн санал явж байгаа. Хүүгийн хөнгөлөлт нь мөн туссан байгаа.

Засгийн газар дээр Үндэсний хороо байгуулагдсан. Үндэсний хорооны дэргэд Ажлын алба байгуулагдаж байгаа. Ажлын алба дээр энэ урсгал зардалтай холбоотой энэ сургалт чадавхжуулах чиглэлийн үйл ажиллагаанууд явагдана. Яг тусгайлан төсвийн төсөл дээр тусгагдаагүй ч гэсэн бусад үйл ажиллагааны урсгал зардал дээрээс

ХХААХҮ-ийн сайдын урсгал зардлуудаас төсвийн зохицуулалт хийх замаар тодорхой ажлуудыг санхүүжүүлээд явах бололцоо байгаа гэж ингэж харж байгаа.

**Р.Сэддорж:** Мандхай гишүүн тодруулга авъя. Нэг минут.

**М.Мандхай:** Энэ нөгөө саяын түрүүний хэлсэн энэ 3.3.4.3-ыг нэлээн бас 2 ч Байнгын хороогоор унагаж босгож байж, ээлжит бусаар батлуулсан байгаа. Тэгээд 25 оны энэ чинь үйл ажиллагааны чинь төлөвлөгөөнд танай дээр бүтцийн хувьд Жижиг, дунд үйлдвэрийн газарт хэрэв хэрэгжих гэж байгаа бол үүнийг төлөвлөгөөндөө тусгаж өгөх саналтай байна.

Тэгэхгүй болохоор нэг бол үндэсний хороон дээр ажлын албан дээр чадавхжуулах хэсэг нь орчхож байгаа, нэг бол энэ дээр зээл олголт нь гээд ингээд явчихаар нөгөө энэ өндөр ач холбогдолтой заалтууд маань ингээд гээгдэх магадлалтай. Эсвэл аль нэг заалт нь орхигдох хэрэгжихгүй байх ийм эрсдэл байгаад байгаа учраас энэ 3.3.4.3-ыг энэ ХХААХҮЯ-ндаа Жижиг, дунд үйлдвэрийн газарт нь тусгаж оруулахгүй бол хоршооны загвар төслүүд бэлтгэх хоршоод дээрээ яг яалт ч үгүй танай яаманд харьяалагдахаар харагдаад байгаа.

Тэгэхээр энэ заалтыг бүр тусгаж өгч оруулмаар байна.

**Р.Сэддорж:** Санал хэлчхэв үү, тийм ээ. Санал протоколд тэмдэглэгдэж байна.

Би нэг хэдэн асуулт асуух гээд байгаа юм.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний дагуу I дүгээрт, энэ Хэрлэн-тооно, Орхон-Онги төслийн бэлэн байдлыг хангах ажлыг 2025 онд 100 хувь хэрэгжүүлнэ гэсэн байна.

Төслийн бэлэн байдлыг хангах гэдэгт ямар ажлууд хийгдэх вэ? Усны нөөц хуримтлуулах ажлуудыг ганц говийн бүсэд гэлтгүй хурдан иуурхай хийх нөөц боломж байгаа юу? Гадаргын усыг хуримтлуулах, нөөцлөх, хямд төсөр хөнгөн иуурхай хийгдэж болох өөр арга замууд судалж үзсэн үү? Төслийн бэлэн байдлыг хангасаар байтал хугацаа яваад байгаа гэдгийг бас анхаарч байгаа юу гэж Байгаль орчны яамнаас.

ЭХЯ байхгүй байна. Гантөмөр сайд бараг мэдэж байгаа даа. Тавантолгойн цахилгаан станцын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийнэ. 2025 онд 20 хувьд хүргэхээр тодорхойлсон байгаа. Тэгээд энэ 20 хувьд яг ямар ажлууд хийгдэх бол оо? Цахилгаан станц хэзээ ашиглалтад орж, эрчим хүчээ өгч эхлэх вэ гэж тооцож байна вэ?

3-д нь, ЗТЯ Гашиун сухайт Ганцмод боомтод хил дамнасан төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэх терминалыг барих ажил байгаа. Мөн Шивээхүрэн дээр бас холболтын төмөр зам гээд байгаа. Тэгээд 25 онд 20 хувьтай гүйцэтгэхээр тусгасан байна. Эдгээр бүтээн байгуулалтын ажлууд хэдэн жилийн хугацаанд бүрэн дуусах вэ? Яг. Үүнээс 20-оос илүү хувьд гүйцэтгэх боломж байхгүй юу? Ирэх онд.

Мөн төмөр зам дагасан энэ хашаан дээрээ энэ төлөвлөлт хийдэггүй юу, хийхгүй юу. МТЗ-ын тэр 400 гаруй километр зам дээр чинь Дорноговь, Өмнөговь аймгийн хашиж болохгүй, малууд дайрагдаад ер нь дөхөж байна шүү. Сая Манлай сумын 80 саалийн ямаагаа нэг айл дайруулсан байна. Нэг өдөрт л 15 тэмээ дайрч байна. Тэгээд яагаад төмөр замаа ингээд хашихгүй байж байж, ачаагаа тээврээ эхлүүлж байгаа юм бэ? Энэ хохирлыг бүрэн барагдуулаарай.

4. Сэргээгдэх эрчим хүчний төслийн хэрэгжилт 70 хувьтай

байгаагаас 25 онд 80 хувь руу хүргэнэ гэж байгаа. Гадаадын зээл тусламжаас санхүүжнэ гэсэн байна. Би бол Энхцэцэг гишүүнтэй бол санал нэг байгаа. Заавал зээл авч энэ нар салхийг хэрэгжүүлэх шаардлага байна уу? Хувийн хэвшилдээ найдаад бас тодорхой хэмжээнийх нь энэ төсвийн хөрөнгөөр хийж болдоггүй юм уу?

Нар цахилгааны станцын эх үүсвэрийг айл өрхүүд хэрэглээндээ нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх тийм бодлого бололцоо байгаа юу? Амины орон сууцуудад нарны эрчим хүчний үүсгүүрийн өрхийн хэрэглээндээ нэвтрүүлэхэд магадгүй хөнгөлөлттэй зээл олгох, тэр нөгөө нарны панел хавтангуудыг нь урт хугацааны тийм хүүгүй зээлээр өгөх ийм зүйлүүд байна уу?

5-д нь, Монгол Францын хамтарсан ураны төслийн бэлтгэл ажлыг эхлүүлнэ. 25 онд хүрэх зорилтыг 100 хувь гэж үзэж тодорхойлжээ. Үүний бэлтгэл ажлыг эхлүүлэхэд ямар ажлууд олгох вэ? Цаашид төсөл бүрэн хэрэгжиж үйл ажиллагаа явагдах эхлэх хугацаа хэзээ бол оо гэсэн ийм 5 асуулт байна. Эдийн засгийн яамнаас.

Байгаль орчны яам байна уу. Байгаль орчны яам байна уу. 1 номер уу, 1 номер.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мөнхзул.

Орхон-Онги, Хэрлэн-тооно төслийн ажлууд явагдаж байгаа. Нэлээн удаан үргэлжилж байгаа. Тэгээд энэ ажил маань цаашаа явагдахын тулд Хилийн усны хэлэлцээрийн үр дүнгээс шалтгаалаад цаашаа энэ ажил яаж явагдах вэ гэдэг асуудал тодорхойлогдох ёстой байдаг. Тэгтэл сая болсон хилийн усны хэлэлцээрээр энэ асуудал бол бас зохих түвшинд бас хөндөгдөж яригдаагүй байж байгаа. Эхний шатны

ажил бол яригдаад явж байгаа ч гэсэн ТЭЗҮ хийх, тэр ТЭЗҮ-г хүлээн зөвшөөрөх эсэх асуудал, тэгээд цаашаа нөгөө усны хуримтлалын асуудлууд, цаашаа дамжуулах хоолой гээд хийгдсэн ТЭЗҮ-ийн маань хугацаа бас ингээд 2, 2 жил болоод дуусчхаад хүлээн зөвшөөрөхөд хэцүү байдалд орчихсон. Ахиад энэ ТЭЗҮ-г чинь яаж сайжруулах вэ, хэрэгжүүлэх вэ гэдэг тал дээр судалгааны ажлууд нь бас шат дараа хийгдээд явж байгаа. Хамгийн түрүүнд авах арга хэмжээ гэвэл энэ хилийн усны хэлэлцээрийн үр дүнг цаашаагаа ахиулж байж энэ ажил маань явах чиглэлтэй.

Тэгээд бид нар энэ чиглэлээр бас ажлын хэсэг гараад хэд хэдэн уулзалтууд хийгээд холбогдох санал, дүгнэлтээ бас Засгийн газарт танилцуулах гээд бэлдчихсэн явж байгаа. Энэ 7 хоногт энэ 3 дахид танилцуулна гэсэн боловч бас хойшлогдоод дараагийн 7 хоног болоод явчихсан байж байгаа. Мэдээллийг нь жичдээ хүргүүлэх боломжтой.

**Р.Сэддорж:** ЭХЯ байгаа юу? Ирээгүй байна. Эдийн засгийн яам хариулах уу? 3 номер. Тавантолгойн станцын 20 хувьд хүрнэ гэж байна. Хэзээ станц ашиглалтад орох вэ?

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Тавантолгойн ДЦС-ын төсөл тендер шалгаруулалт нь зарлагдаад ЭХЯ дээр санал ирүүлсэн компаниуд хоорондоо шүүхийн маргаан үүсгэсэн байгаа. Энэ шүүхийн маргааныг ойрын хугацаанд шийдвэрлэгдээд хөрөнгө оруулалтын асуудал нь эцэслэн шийдэгдэнэ гэж ойлгож байгаа.

**Р.Сэддорж:** ЗТЯ Батболд дарга. 9 номер.

**С.Батболд:** Сэддорж гишүүний асуултад хариулъя. Шивээхүрэн боомтын хил дамнасан төмөр зам болон логистикийн терминалын барилгын ажил үндсэндээ дууссан. Манайхан тэнд

бас урьдчилсан байдлаар хүлээж авах ийм комисс ажиллаад явж байна.

Гашуун сухайт боомтынх бол хил дамнасан зам нөгөө бүтээн байгуулалттай холбоотой гэрээ байгуулах ажил явж байна. Сайд бас яг энэ хүрээнд сая Хятад улсад ажиллаж байгаад ирсэн. Тэр Гашуун сухайт дээр баригдаж байгаа терминалын ажлууд 2, 3 янзын ажил явагдаж байгаа. Зарим нь төмөр замын хүрээнд байгаа, зарим нь авто-аас автод шилжүүлэх бас ийм терминалууд явж байгаа. Энэ дээр яг нарийн мэдээллийг би тодорхой аваад бас өгье. Гүйцэтгэл нь бас өөр өөр байгаа.

Саяын таны асуусан Зүүнбаян Тавантолгой чиглэлийн төмөр зам бол зураг ТЭЗҮ-ээрээ .... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя, 9 номер.

**С.Батсайхан:** Төмөр замын энэ зам бол 2 талаараа хашаа байхгүй байгаа. Энэ зэрлэг амьтдыг хамгаалах ОУБ мөн бусад байгууллагуудаас энэ төмөр замыг хашсан энэ хашаа торыг эсэргүүцээд хийлгэхгүй байгаа. Энэ дээр бол хийж болохгүй. Харин зэрлэг амьтан, малын дээгүүр болон доогуур гарцуудыг сайн хий гэдэг ийм чиглэл өгдөг. Ингээд УБТЗ-ын энэ төмөр зам дагуу ч гэсэн энэ торон хашаануудыг ав гэдэг шаардлага тавьдаг. Өнгөрсөн хугацаанд бид нар бас 2км орчим газрын энэ торон хашааг бол авсан байгаа.

Тэгэхээр энэ бол байгаль орчин, олон улсын байгууллагуудаас энэ төмөр зам дагасан хашихыг бол хориглоод байгаа. Тийм учраас энэ дээр бол байхгүй байгаа.

**Р.Сэддорж:** ЭХЯ-ны талаар Эдийн засаг, хөгжлийн яам хариулах уу? Сэргээгдэх эрчим хүчний талаар. 1 номер.

Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Энэ оны төсөв дээр сэргээгдэх эрчим хүч ер нь эрчим хүчтэй холбоотой их олон заалтууд орсон байгаа. Тэр олон заалтуудаас нэлээд нь хувийн хэвшилээр хийх заалтууд байгаа. Яг сэргээгдэх эрчим хүчний тухайд болохоор тэр эрчим хүчний зохистой харьцаа гэж ойлголт байдаг юм байна. Түүний дагуу ямар түвшинд нүүрс байх вэ, ямар түвшинд сэргээгдэх эрчим хүч, түүн дотроо нар, салхи, усны цахилгаан станц байх вэ гэдэг тооцооллын нарийн хийдэг юм байна.

Тэгээд үүний дагуу тооцооллууд нь хийгдээд сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой нэлээд төслүүд орсон байгаа. Цаашидаа ер нь бол таны хэлдгээр бас тэр бага оврын төслүүдийг хувийн хэвшилээр хийхийг дэмжих, тэр хувийн хэвшилээр ер нь сэргээгдэх эрчим хүчний салбарт оролцуулах тэр агуулгатай заалтууд орсон байгаа. Гагцхүү тэр нар салхин дээр бол хураагуур батарейн асуудал байх ёстой юм билээ. Мөн бусад ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт үргэлжлүүлье. 1 номер.

**Ц.Эрдэнэбат:** Тэр хураагуурын асуудал байх ёстой юм билээ. Тэгж байж яг хэрэв төвийн эрчим хүчтэй холбогдож байгаа тохиолдолд хураагууртай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг дэмжинэ гэсэн ЭХЯ-ны байр суурь байгаа юм билээ. Одоогийн бас сэргээгдэх эрчим хүчний компаниудыг 1-д, тарифаа ахиж харах, 2-т, батарейтай болгох шаардлагыг ЭХЯ-наас тавьж байгаа юм билээ.

Тэгээд тэр тохиолдолд тэр төслүүдийг нь сунгахаар иймэрхүү бодлогын заалтууд орчихсон байгаа. Ер нь бол эрчим хүчний реформ гэсэн чиглэлээр Засгийн газар дээр ажлын хэсэг гараад, тэгээд энэ хүрээндээ энэ асуудлууд цаашидаа тодорхой болоод жигдрээд явах байх.



**Р.Сэддорж:** Гантөмөр сайдын микрофоныг өгье.

**Л.Гантөмөр:** Тэгэхээр бид нар энэ үйл ажиллагааны төлөвлөгөө, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа нэг зүйл дээр аягүй хатуу төвлөрсөн. Тэр бол ирэх он жилүүдэд Монголын эдийн засгийг бат суурьтай байх ёстой гэж, Монголын эдийн засгийн суурь их тодорхой байх хэрэгтэй гэж. Жишээлбэл энэ жилийн төсвийн орлогын хэмжээг ингээд тооцоолоод 30 их наяд хүрэх нь гээд гаргахаар итгэдэггүй. 30 хүрэнгүүт хани унах тухай ярьдаг. Эс бол ирэх он жилийн экспортын хэмжээг 19 тэрбум доллар хүрнэ гэхээр итгэдэггүй. Яагаад гэвэл зам тээвэр, ложистик, эрчим хүч гээд ингээд нөгөө бэлэн байдлын индексүүд нь хүрдэггүй.

Тийм учраас та бүхэн маань нэг зүйлийг их сайн ойлгож дэмжиж өгөөрэй. Жишээлбэл Гашуун сухайт Ганцмодны төмөр замын холболтыг заавал хийх хэрэгтэй. Ингэж байж магадгүй бид нарын энэ ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариултыг үргэлжлүүлье. Гантөмөр сайдын микрофон.

**Л.Гантөмөр:** Ингэж байж бид нарын хөгжлийн төлөвлөгөө, ирэх оны төсөв маань биеллээ олно гэдгийг хэлмээр байна, 1.

2 дугаарт, Тавантолгойн цахилгаан станцыг ямар ч үнэ цэнээр хамаагүй барьж эхлүүлнэ. Энэ шүүхийн маргаан болоод бусад лоббины ажлыг бол таслан зогсооно оо. Үүнийг Засгийн газар хатуу шийдсэн байгаа гэдгийг та бүхэндээ хэлмээр байна.

Бас нэг зүйл энэ Ронатай холбоотой уран олборлох төслийг хэрэгжүүлнэ. Энэ ажлыг ондоо багтаагаад оруулж ирнэ. Мөн эрчим хүчин рүү хандаж байгаа хөрөнгө

оруулалтуудыг, асуудлыг эрчим хүчний цогц шинэчлэлийн бодлоготойгоо уяад хийх юм. Үүнийг хийхгүйгээр цаашаа үйлдвэрлэл, уул уурхай, уул уурхай нь магадгүй хөгжил гэдэг зүйл ерөөсөө харагдахгүй байгаа.

Тийм учраас Сэддорж даргын санаа зовоод байгаа энэ эрчим хүчтэй холбоотой асуудал бол ... /минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариултыг үргэлжлүүлье. Гантөмөр сайдын микрофон.

**Л.Гантөмөр:** Мөн говийг усжуулах асуудал бол заавал хийгдэнэ. Говь устай, говь устай бололгүйгээр цаашаа аж үйлдвэр гэдэг зүйл байхгүй. Тийм учраас говийг устай болгох төслийг Эрдэнэс тавантолгой, Эрдэнэс Монгол компани толгойлоод хийгээд явна гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Энхтүвшин гишүүн. Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Хойд талын энэ хавсралтууд дээр сайн ажилламаар, ажлын хэсэг ажилламаар санагдлаа. Тэгээд энэ зорилтот үр дүн гэж нэг өөр дүн тавьчхаад, тэгээд хэмжих үзүүлэлтүүд нь жишээлбэл ингээд буруу зөрөө явж байна. Би энд тодорхой жишээ хэлье. Энэ төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн гэдэг дээр бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ гээд энэ дээр жишээлбэл танхимын энэ бизнес орчны судалгааг 2,8-д хүргэнэ гэсэн мөртөө дараа нь 1.10 дээр нь болохоор 3,5-д хүрнэ гэсэн. Үүнийгээ юу нэг тодорхой болгоод засаарай гэж хэлмээр байна.

Дээр нь дахиад өшөө жишээ гэхэд 4 улирлын аялал жуулчлалын дэд

бүтцийн үйлчилгээг хөгжүүлнэ гэснээ жилд авах жуулчны тоогоо тавьчихсан. Тэгэхээр энэ улирлаараа, жишээлбэл тавихгүй бол нийт авдаг тоогоо энэ дээр тавиад бол бид нар жишээлбэл энэ гарчиг, зорилт 2 чинь ингээд зөрчхөж байна.

Дээр нь жишээлбэл энэ дээр эдийн засаг дахь төрийн оролцоог жишээлбэл багасгана гэдэг зорилтын доор төрийн өмчит компанийн өгөөжийг дээшлүүлнэ гэсэн ийм үзүүлэлт тавьчихсан ийм байна. Тэгэхээр энэ ард талын би зүгээр харсан юмнууд дээр ингээд ийм авцалдаагүй өөр юмыг өөр хэмжээд байгаа ийм дүр зургууд байгаа учраас үүнийгээ нэг дахиж хараач гэж хэлмээр байна.

Дээр нь энэ хэрвээ энэ сая хөтөлбөрийн үр дүн гэдэг хэсгийн 1.1.2 дээр нь тэр зах зээл дэх эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана гэдэг хэсгийн юу зорилт үр дүн нь буруу гэвэл, энэ заалтыг тэр төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн гэдэг дээр эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана гэдэг заалтыг нэмж оруулах тийм саналтай байна. Үүнийг болохоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хавсралт 2 дээр байгаа хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийг 2028 онд 80 хувь хүргэхээр ингээд зорьчихсон байгаа.

Тэгэхээр энэ үзүүлэлтээс 2025 оны 77 гэдгийг нь ч юм уу нэмж оруулах ийм санал байна.

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүн жишээ нь саналаа бичгээр яаралтай ирэх 7 хоногийн эхэнд л өгөх хэрэгтэй байна.

Ингээд гишүүд маань яаралтай батлах шаардлагатай байгаа учраас ирэх 7 хоногийн нэг дэх өдөр бараг саналуудаа цаасаар бичгээр өгөх нь ээ.

Гишүүд үг хэлж дууслаа.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийн явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц гишүүн дэмжиж байна уу? Өөр санал байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц уншиж танилцуулна.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийн хамт олонд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ